

Мормоны Ном

Суралцагчдын судлах удирдамж



Санал хүсэлт болон зөвлөмж

Энэхүү судлах удирдамжийн талаарх таны санал хүсэлт, зөвлөмжинд бид талархах болно. Санал хүсэлт болон зөвлөмжөө доорх хаяг руу илгээнэ үү:

Curriculum Planning

50 East North Temple Street, Floor 24

Salt Lake City, UT 84150-3200

USA

Э-мэйл: cur-development@ldschurch.org

Нэр, хаяг, гадсаа бичиж үлдээнэ үү.

Мөн судлах удирдамжийн нэрийг

бичнэ үү. Уг судлах удирдамжийн хүч

чадал, цар хүрээ болон хөгжил дэвш-

лийнх нь талаар санал хүсэлт, зөвлөгөө-

гөө үлдээнэ үү.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав.
Солт Лейк хот, Юта муж

© 2012 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 8/96

Орчуулгын зөвшөөрөл: 8/08

Translation of *Book of Mormon Class Member Study Guide*

Mongolian

35684 363

Оршил

Арванхоёр Төлөөлөгчидтэй уулзах уулзалтан дээр Бошиглогч Иосеф Смит “Би ах нарт хэлсэнчлэн Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуур чулуу, түүнчлэн бусад ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг нь мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой” (*History of the Church*, 4:461; Мормоны Номын удиртгал хэсгийг мөн үз) гэжээ.

Мормоны Номыг судлахад тань туслах зорилгоор энэ удирдамж хийгдсэн билээ. Энэ нь дугаарлагдсан хэсгүүдэд хуваагддаг ба хэсэг бүр Мормоны Ном сайн мэдээний сургаалын хичээлтэй холбогддог юм. Та судраас сурсан зүйлсээ илүү сайн хэрэгжүүлж, ангид өрнөх ярилцлагад үнэ цэнэтэй хувь нэмэр оруулахад эдгээр асуултуудаас ашиглаж болно.

Ингэснээр та суралцагчдыг илүү амжилттай суралцахад нь туслах сайн мэдээний сургаалаас багшлах үүрэг хариуцлагад нь хувь нэмэр оруулж байгаа юм. Их Эзэн багш

нар “үнэний сүнсээр номлох” хэрэгтэй гэдгийг мөн “үнэний үгийг” хүлээн авдаг тэдгээр нь үүнийг “үнэний Сүнсээр” (D&C 50:17, 19) хүлээн авдаг гэдгийг хэлжээ. Хичээлдээ суухдаа асуулт асууж, туршлагаа хуваалцаж, бусдыг болон багшийгаа анхааралтай сонсож, хичээлд туслах бэлтгэлтэй ир. Та унших даалгавруудыг хийж, судлах удирдамж дээрх асуултуудыг тунгаан бодсоноор Их Эзэний хэлсэн “Иймийн тул, номлодог тэр нь мөн хүлээн авдаг тэр нь бие биенээ ойлгодог, мөн хоёул сэнхэрч мөн хамтдаа баясдаг буюу” гэх үгийг амьдралдаа илүү сайнаар хэрэгжүүлэх бэлтгэлтэй байж чадна.

Энэ судлах удирдамж нь гэр бүлд ч үнэ цэнэтэй эх сурвалж болдог. Та гэр бүлдээ сайн мэдээнд төвлөрсөн ярилцлагыг өрнүүлэхийн тулд уг судлах удирдамжийн асуултуудыг ашиглаж болно. Мөн энэхүү удирдамжийн хэсэг бүр нь гэр бүлийн ярилцлага хийхэд зориулсан санаануудыг агуулдаг. Гэр бүлийн гишүүд гэр бүлийн үдшийн хичээлийг бэлтгэхдээ тэдгээр зөвлөгөөнүүдээс ашиглаж болно.

“Манай шашны тулгуур чулуу”

1

Дараах судруудыг залбиралтайгаар судал: 1 Нифай 13:38–41; 19:23; 2 Нифай 25:21–22; 27:22; 29:6–9; Мормон 8:26–41; Ифер 5:2–4; Моронай 1:4; 10:3–5; Сургаал ба Гэрээ 10:45–46; 20:8–12; 84:54–58. Мөн Мормоны Номын удиртгал материалуудыг судал.

- Мормоны Номын нүүр хуудасны 2-р догол мөрөнд Мормоны Номын зорилгыг юу гэж бичсэн байна вэ?
- Та Есүс Христийн талаар Мормоны Номноос юу сурсан бэ? Мормоны Ном Есүс Христийн талаарх таны гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ?

- Мормоны Номын аль хэсэг танд хамгийн их нөлөөлсөн бэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлээрээ Ерөнхийлөгч Марион Ж.Ромнигийн хэлсэн дараах үгсийг унш:

“Хэрэв эцэг эх гэртээ Мормоны Номноос хоёулаа мөн хүүхдүүдтэйгээ залбиралтайгаар, тогтмол судлах юм бол уг агуу номны сүнс бидний гэр оронд болон тэнд буй хүн бүрт нөлөөлөх болно гэдэгт би итгэлтэй байна. Хүндэтгэл бишрэлийн сүнс өсөн нэмэгдэж; бие биенээ хүндэтгэх хүндэтгэл улам өснө. Зөрчилдөөний сүнс холдож зайлах болно. Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ агуу их

хайраар болон мэргэн ухаанаар зөвлөлдөн, хүүхдүүд эцэг эхийнхээ зөвлөгөөнд илүү дуулгавартай, нээлттэй байж чадна. Зөв шударга байдал ч өсөн нэмэгдэнэ. Амар амгалан, баяр баясгалан, аз жаргал авчрах итгэл, хайр, энэрэл—Христийн цэвэр хайр бидний гэр бүлд болон амьдралд цутгах болно” (in Conference Report, 1980 оны 4-р сар, 90; эсвэл *Ensign*, 1980 оны 5-р сар, 67).

Эдгээр зөвлөгөөг дагаснаар гэр бүлд тань ирэх адислалуудын талаар ярилц. Мормоны Номыг судлахын тулд өдөр бүр гэр бүлээрээ цугларах төлөвлөгөө гарга. Гаргасан төлөвлөгөөгөө хариуцлагатай дагахад нь гэр бүлийн гишүүн бүрийг дэмж.

“Бүх зүйл Түүний тааллаар”

1 Нифай 1–7

- Мормоны Номонд гардаг хамгийн эхний үйл явдал бол Лихай гэр бүлийн хамт Иерусалимыг орхин одсон тухай юм. Ямар нөхцөл байдлууд тэднийг Иерусалимыг орхин явахад хүргэсэн бэ? (1 Нифай 1:4–15, 18–20; 2:1–3-г үз)
- Яагаад Иерусалим дахь хүмүүс Лихай болон бусад бошиглогчдын захиасыг эсэргүүцсэн бэ? (1 Нифай 1:19–20; 2:12–13; 16:1–2-г үз) Яагаад зарим хүмүүс өнөө үед ч Их Эзэн болон Түүний үйлчлэгчдийн эсрэг тэмцдэг вэ? Та бошиглогчдын заасан зүйлст зүрх сэтгэлээ нээлттэй байлгах талаар Нифайгаас юу сурч болох вэ? (1 Нифай 2:16, 19-г үз)
- Яагаад Лихайн гэр бүл гуулин ялтсуудыг олж авах хэрэгтэй байсан бэ? (1 Нифай 3:3, 19–20; 4:15–16; 1 Нифай 5:21–22; Мозая 1:3–7-г үз)

2

Та 1 Нифай 2–4-г уншихдаа Нифайн зан чанаруудыг Лемен болон Лемүелийн зан чанаруудтай харьцуул. Мөн дараах судруудад илүү их анхаарал хандуулж болно: 1 Нифай 1:1; 2:11–13, 16, 19; 3:5, 7, 14–15, 31; 4:1, 3.

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Лихайн гэр бүл яагаад гуулин ялтсуудыг олж авах хэрэгтэй байсан тухай ярилц. Та нар судартай байгаадаа хэрхэн баяртай байгаа талаар ярилц. Тэгээд Мормоны Ном байхгүй найз нарынхаа нэрсийг жагсааж бичихийг гэр бүлийн гишүүдээсээ хүс. Мормоны Номыг тэдэнд өгөх арга замыг залбиралтайгаар тунгааж бод. Мөн та тэдгээр найз нартаа өгөх Мормоны Номыг гэр бүлийн гишүүн бүртээ тарааж өгч болно. Ингэснээр гэр бүлийн гишүүд тань Мормоны Номыг тэдэнд өгөх болно.

1 Нифай 8–11; 12:16–18; 15

Амьдралын модны үзэгдлийн тухай судраас уншихдаа дараах бэлэг тэмдгүүд болон тэдгээрийн утга учрыг тунгаан бод:

Амьдралын мод (1 Нифай 8:10; 11:8–25)

Амьдралын модны жимс (1 Нифай 8:10–18, 30; 15:36; С ба Г 14:7-г үз)

Төмөр бариул (1 Нифай 8:19–24, 30; 11:25; 15:23–24)

Харанхуй манан (1 Нифай 8:23–24; 12:17)

Уст гол (1 Нифай 8:13, 26, 32; 15:26–29)

Агуу хийгээд нүсэр барилга (1 Нифай 8:26–28, 31, 33; 12:18)

- Нифай амьдралын модны үзэгдлийг хараад үүний утгыг нь ойлгохыг хүсдэг (1 Нифай 11:8–11). Нифай тэр мод юуг төлөөлж байгааг хэрхэн ойлгосон бэ? (1 Нифай 11:21–25.) Бурханы хайрыг ойлгоход нь тусалсан юуг Нифай харсан бэ? (1 Нифай 11:13–21, 24, 26–33; Иохан 3:16-г үз)
- Лихай болон Нифай амьдралын мод, түүний жимсийг хэрхэн дүрсэлсэн бэ? (1 Нифай 8:10–12; 11:8–9, 23; 15:36-г үз)
- Лихай үзэгдэлд “тоогүй олон хүмүүсийг” (1 Нифай 8:21) хардаг.

Тэдгээр хүмүүсийг амьдралын мод болон түүний жимсэнд хэрхэн анхаарал хандуулж байгаагаас нь шалтгаалан дөрвөн хэсэгт хувааж болно. 1 Нифай 8:21–33-г уншаад тэдгээр дөрвөн төрлийн хүмүүсийг олж тогтоо. Тэдгээр хүмүүс өнөө үетэй хэрхэн холбогдож байна вэ? Та өөрийгөө эдгээр дөрвөн төрлийн хүмүүсээс аль нь гэж бодож байна вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Амьдралын модны үзэгдлийг илүү сайн ойлгоход нь гэр бүлийн гишүүдэд туслахын тулд дараах үйл ажиллагааг явуул:

Гэр бүлийн нэг гишүүний нүдийг нь боогоод тойруулаад эргүүл. Нүдний боолт нь харанхуй мананг төлөөлж байгааг тайлбарла. Тэгээд Аврагчийн зургийг өрөөний хаа нэгтээ өлгө. Нүд нь боолттой гэр бүлийн гишүүнийг хэн нэгний тусламжгүйгээр тэр зурагт хүрэхийг хүс. Тэр зургийг олж хүрч чадахгүй нь тодорхой болмогц өөр нэг гэр бүлийн гишүүнийг зургийн хажууд зогсоогоод түүнээс уяаны үзүүрээс барихыг хүс (төмөр бариулыг төлөөлнө). Өөр нэг гэр бүлийн гишүүнээр нөгөө нэг үзүүрийг нь бариул. Тэгээд нүд нь боолттой хүнд уяаг бариулсны дараа зураг руу алхахыг хүс.

“Сүнсэнд автагдсан үедээ харсан тэдгээр зүйлүүд”**1 Нифай 12–14**

- 1 Нифай 12 бүлэгт Нифай өөрийнхөө болон ах нарынхаа ирээдүйн үр удмын талаарх

үзэгдлийг дүрсэлсэн байдаг. Амьдралын модны үзэгдэлд (харанхуй манан, агуу хийгээд

нүсэр барилга, уст гол) гарсан тэдгээр бэлэг тэмдгүүд хэрхэн Нифайн үр удмын уналтын талаар зөгнөж байна вэ?

- Нифай “харийнханы үндэстнүүдийн дунд” юуны үүслийг харсан бэ? (1 Нифай 13:4–5-г үз) Агуу хийгээд жигшүүрт сүмийн үүсгэгч нь хэн бэ? (1 Нифай 13:6-г үз)
- Агуу хийгээд жигшүүрт сүм Библиетэй холбоотой юу хийсэн бэ? (1 Нифай 13:20–26-г үз) Яагаад? (1 Нифай 13:27-г үз) Библид ойлгоход хэцүү байдаг боловч Мормоны Номонд тодорхой, ойлгомжтой тайлбарласан ямар сургаалууд байдаг вэ? Мормоны Ном Библийг илүү сайн ойлгоход болон Библийн талаарх гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд танд хэрхэн тусалсан бэ?

- Нифай эцсийн өдрүүдэд Их Эзэний Сүмийн гишүүдийн тоо харьцангуй цөөхөн байх боловч тэд агуу хийгээд жигшүүрт сүмийн хавчлагыг даван гарах болно гэдгийг харжээ. Нифай Бурханы Гэгээнтнүүдийг юугаар зэвсэглэхийг харсан бэ? (1 Нифай 14:14-г үз) Та нар хэрхэн “зөв шударга байдал хийгээд Бурханы хүчээр зэвсэглэх” вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

1 Нифай 12–14-р бүлгээс сонгосон шүлгүүдийг гэр бүлээрээ хамт унш. Та эдгээр бүлгүүдээс суралцахдаа Нифайн хэлсэн бошиглоуудад анхаарлаа сайн хандуулаарай. Гэр бүлийн гишүүдэд бошиглоуудыг судар дээрээ тэмдэглэхийг санал болго. Биелэгдсэн бошиглоуудыг жагсааж бич.

“Үнэнийг дуртайяа анхааран сонсож, үүнд анхаарлаа хандуул”

5

1 Нифай 16–22

1 Нифай 16–18-р бүлгийг судлахдаа Нифай ямар арга замаар өөрийн дуулгавартай байдал, итгэл, зориггоо баталсныг эрж ол. Нифайн жишээг дагах арга замуудыг бодож ол.

- Нифайн сорилт бэрхшээлд хандсан хандлага нь түүний гэр бүлийн гишүүдийн зовлон бэрхшээлд хандсан хандлагаас хэрхэн ялгагдаж байна вэ? (1 Нифай 18:16-г 1 Нифай 16:18–20, 34–36; 17:21-той харьцуул) Зовлон бэрхшээл тулгарсан үед бид хэрхэн гомдоллохгүй байх вэ?

Бурханы зарлигуудад дуулгавартай байх талаар өгүүлсэн дараах судруудыг судал. Та эдгээр судрыг тэмдэглэн авч болно.

1 Нифай 3:7

С ба Г 130:20–21

1 Нифай 17:3

Абрахам 3:25

С ба Г 82:10

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Нэг чанга сүлжсэн, нэг сул сүлжсэн олсыг ол. Чанга сүлжсэн олсыг харуулаад үүнийг маш чанга сүлжсэн гэдгийг тайлбарла. Олсыг бат бөх байлгахад сүлжээс чанга байх нь чухал байдаг шиг гэр бүл нэгдмэл байх нь чухал гэдгийг тайлбарла. Тэгээд сул сүлжсэн олсыг харуулж сүлжээсийг сул сүлжихэд олс амархан сулардаг шиг гэр бүлүүд нэгдмэл биш бол амархан сул дорой болдог талаар тайлбарла.

1 Нифай 16–18-р бүлэгт гардаг түүхүүдийг унш. Лихайн гэр бүлийн гишүүн нэг бүрийн үйлдэл гэр бүлийн нэгдмэл байдалд хэрхэн

нөлөөлж байгааг тунгаа. Гэр бүлээ илүү нэгдмэл болгохын тулд гэр бүлээрээ юу хийж болох талаар ярилц.

“Эрх чөлөө хийгээд мөнх амьдралыг сонгох эрхтэй”

6

2 Нифай 1–2

2 Нифай 1-р бүлэг нь Лихай амьдралынхаа төгсгөлд өөрийн хөвгүүдэд өгсөн зөвлөгөөг агуулдаг. Та энэ бүлгийг судлахдаа Лихай өөрийн хөвгүүдэд хий гэж зөвлөсөн зүйлүүдийг болон түүний зөвлөгөөг дагаснаар ирэх амлалтуудыг эрж ол.

Та 2 Нифай 2-г судлахдаа *эрх чөлөө, үйлдэх, сонгох* зэрэг үгсийг эрж ол. Тэдгээр үгсийг тэмдэглэж болно. Эдгээр үгсийн ач холбогдлыг тунгаан бодох цаг гарга.

- 2 Нифай 2:6–8-г унш. Та хэрхэн “эдгээр зүйлийг мэдүүлэх вэ”? Эдгээр зүйлийг мэдүүлэх нь Аврагчийн цагаатгалд талархах талархлыг тань хэрхэн илэрхийлэх вэ?
- 2 Нифай 2:15–25-г уншиж, (1) Адам, Ева хоёрын хориглогдсон жимснээс хүртэхээс өмнөх нөхцөл байдлыг мөн (2) жимснээс хүртсэний дараа юу өөрчлөгдсөнийг эрж ол. Адам, Ева хоёрын уналт дэлхийд эсрэг талуудыг авчирснаар

бид ямар адислалуудыг хүртэх боломжтой болсон бэ? (2 Нифай 2:23–27-г үз; Мосе 5:10–12)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Мормоны Номноос амархан олох боломжтой асуултуудыг хүмүүс номлогч нараас асуудаг гэдгийг тайлбарла. Гэр бүлийн гишүүдийг номлогчийн дүрд тоглож, дараах асуултуудыг тэднээс асууж байна гэж төсөөл. 2 Нифай 2-оос холбогдох судруудыг ашиглан асуултуудад хариулахыг хүс.

1. Есүс бол Аврагч гэж юу гэсэн үг вэ? (2 Нифай 2:5–10-г үз)
2. Бурхан яагаад дэлхий дээр сайн, муу хоёулаа байхыг зөвшөөрсөн юм бэ? (2 Нифай 2:11–13-г үз)
3. Би олон зарлиг тушаалыг дагахыг хүсэхгүй байна. Хэрэв би Есүсийн сургаалуудыг дагавал миний эрх чөлөө хязгаарлагдахгүй гэж үү? (2 Нифай 2:26–29)

“Би хэнд итгэсэнээ мэдэж байна”

7

2 Нифай 3–5

• Та 2 Нифай 3-р бүлгийг судлахдаа бошиглогч Иосеф Смитийн талаарх сургаалуудыг ол. Та Иосеф Смитийн тусламжтайгаар хэрхэн адислагдсан бэ?

• Нифай уруу таталт болон нүглүүдийн улмаас өөрийгөө “хүрээлэгдсэн нэгэн” гэж бодох үедээ хэрхэн найдварыг олсон бэ? (2 Нифай 4:18–25-г үз) Хүлээн авсан

адислалуудаа санах нь хэцүү цаг үеийг даван туулахад хэрхэн туслах вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлээрээ 2 Нифай 4:15–35-г бүхэлд нь эсвэл заримыг нь унш. Судрын энэхүү хэсгийг “Нифайн дуулал” гэж нэрлэдгийг тайлбарла.

Энэ нь Нифайн гүн гүнзгий сэтгэгдлийг илэрхийлдэг. Нифай шиг “дотоод сэтгэлийн зүйлээ бичиглэх нь” яагаад чухал болохыг ярилц (2 Нифай 4:15). Гэр бүлийн гишүүдийг өөрсдийн мэдрэмжээ тогтмол бичиж байхыг дэмж. Тэд магадгүй өөрсдийн мэдрэмжийг дуу эсвэл шүлэг болгон бичихийг хүсч болно.

“Ай Бурханы маань сайн сайхан хэчнээн агуу билээ”

8

2 Нифай 6–10

2 Нифай 9-р бүлэг нь авралын төлөвлөгөөний төв болох Есус Христийн цагаатгалын тухай Нифайн дүү Иаковын хэлсэн үгсийг агуулдаг. Энэ бүлгийн сургаалуудыг ойлгохын тулд *зуурдын үхэл* болон *сүнсний үхлийн* нөхцлүүдийг ойлгох нь чухал. Эдгээр нөхцлүүдийн жишээг харахын тулд, Библийн толь бичиг, “Үхэл”-г үз 655.

- Аврагч зуурдын үхэл болон сүнсний үхлийг даван дийлэхийн тулд юу хийсэн бэ? (2 Нифай 9:5–7, 12, 21–22; Лук 22:44; Мозая 3:7; С ба Г 19:16–19-г үз)
- Иаковын хэлсэнчлэн “Бурханы хаант улсад аврагдахын” тулд мөн Бурханы оршихуйд үүрд мөнхөд үлдэх эрхтэй болохын тулд бид юу хийх ёстой вэ? (2 Нифай 9:18, 21, 23–24, 39, 41, 50–52-г үз)
- Цагаатгалаас ирэх бүх адислалыг хүлээн авахад бидэнд саад болдог ямар зан чанар, үйлдлүүд байдаг вэ? (2 Нифай 9:27–38-г үз)

- Иаков Нифайн үр удам “итгэлгүйн учир бие махбодоороо мөхнө” мөн Иерусалим дахь Иудейчүүд Аврагчийг цовдолж, нүглүүдийнхээ учир тараагдах болно хэмээн бошиглосон юм (2 Нифай 10:2–6). Тэд Түүнд итгэж, нүглүүдээ наманчлахад Их Эзэн тэдний төлөө юу хийдэг вэ? (2 Нифай 10:2, 7–8, 21–22; 1 Нифай 21:15–16; 2 Нифай 9:1–3, 53; 30:2-г үз) Энэ нь бидэнд хувь хүний хувьд хэрхэн нөлөөлдөг вэ?

Хэрхэн доорх шүлгүүд дэх үг мөн шүлэг бүр Иаковын хэлсэн үгсийн утгыг илүү тодорхой болгож байгааг ол:

2 Нифай 9:10	2 Нифай 9:28
2 Нифай 9:14	2 Нифай 9:39
2 Нифай 9:18	2 Нифай 9:51

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Аврагч хүн нэг бүрийн төлөө болон гэр бүлүүдийн төлөө юу хийсэн тухай ярилцахыг гэр бүлийн гишүүдээс хүс.

2 Нифай 11–25

2 Нифай 11–25 дахь Исаиагийн сургаалаас суралцаж эхлэхийн өмнө Ахлагч Бойд К.Пакерын хэлсэн үгсийг унш:

“Мормоны Ном бол судар юм. Энэ нь Есүс Христийн бас нэгэн гэрээ хийгээд улмаар Библийн хэл буюу бошиглогчдын хэлээр бичигдсэн.

Ихэнх хэсэг нь Шинэ Гэрээнд гардаг хэллэгийг ашигласан байдаг. Жишээлбэл: англи хэлэнд *spoke гэдэг үгийг spoke, to* гэдэг үгийг *unto, thus* гэдэг үгийг *it came to pass* гэдэг үгээр орлуулж мөн *thou* болон *thine* хэмээх хуучны төлөөний үгсийг ашигласан байдаг.

Энэ хэл ярианы хэмнэл болон утга зүйг ойлгохын тулд та олон хуудас унших шаардлагагүй. Үнэндээ ихэнх өсвөр насныхан Мормоны Номын утга зүйг амархан ойлгодог.

Тийнхүү та амархан ойлгодог болж эхлэх үед нэгэн саад тогтортой тулгарах болно. Судрын хэл нь хуучин гэрээний бошиглолын хэв маягтай болж эхэлнэ. Хуучин Гэрээний бошиглогч Исаиагийн бошиглолуудаас эш татсан олон хэсэг байдаг. Эдгээр хэсгүүд нь Мормоны Номыг

зөвхөн сонирхон уншиж байгаа хүмүүст хаалт болон хөндөлсөж, цаашид унших сонирхлыг нь буруулдаг.

Уншихгүй байх нь дээр ч юм шиг уруу таталтын мэдрэмж төрж магадгүй. Гэсэн хэдий ч битгий бууж өгөөрэй! Уншихаа битгий зогсоогоорой! Хэчнээн ойлгохгүй байлаа ч гэсэн ойлгоход хэцүү Хуучин Гэрээний бошиглолуудыг үргэлжлүүлэн уншаарай. Хэрэв та зөвхөн гүйлгэж хараад, багахан ойлголтыг олж авч байгаа бол эсвэл зөвхөн үгнүүдийг уншиж байгаа бол үргэлжлүүлэн илүү сайн хичээх хэрэгтэй. ...

... Их Эзэн Мормоны Номонд Исаиагийн бошиглолуудыг хадгалан үлдээсэн нь ямар нэгэн зорилготой билээ. Гэсэн хэдий ч тэдгээр бошиглолууд нь үл тоомсорлогч нэгэнд ачаа дарамт болсон юм.

Исаиагийн бошиглолуудыг уншаагүй тэд олж авах ёстой хувийн үнэт эрдэнэсээ алдаж байна гэсэн үг.” (in Conference Report, 1986 оны 4-р сар, 76–77; эсвэл *Ensign*, 1986 оны 5-р сар, 61).

“Тэрээр тэднийг бүгд өөрт нь ирэхийг урьдаг”

2 Нифай 26–30

2 Нифай 26–30 нь хожмын өдрүүдийн талаар хүчирхэг бошиглолуудыг агуулдаг. Нифай Сатаны мэхлэлтэнд хууртагдаж, үнэнээс холдох тэдгээр хүмүүсийн талаар бошиглосон байдаг. Гэсэн хэдий ч тэрээр сайн мэдээний Сэргээлт

болон зөв шударга тэдгээрт өгөгдөх адислалуудыг зөгнөн харжээ.

- Биднийг мэхлэхийн тулд ашигладаг Сатаны ямар арга барилын талаар 2 Нифай 28-р бүлэгт гарч байна вэ? Хэрхэн тэдгээр арга зальд автахгүй байх вэ? (жишээ

нь, 1 Нифай 15:24; 2 Нифай 28:30; Алма 17:2–3; Моронай 7:15–19; С ба Г 21:1–6; 46:7-г үз)

- Бид Библийг судлахын зэрэгцээ яагаад Мормоны Номыг судлах ёстой вэ? (2 Нифай 29:4–14; 2 Нифай 28:30-г үз)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлийн нэг гишүүнийг өрөөний голд зогсоо. Түүний баруун гар тал бидний амьдралдаа хийж болох бүх сайн сайхан зүйлсийг төлөөлж байгааг тайлбарла. Мөн өрөөний захаар байгаа баруун гар талын хэсэг нь бүр хамгийн сайн сайхан зүйлсийг төлөөлж байгааг хэл. Зүүн гар тал нь амьдралдаа хийж болох бүх буруу муу зүйлсийг төлөөлж байгааг мөн өрөөний захаар байгаа зүүн гар талын хэсэг бүр хамгийн буруу, муу муухай зүйлсийг төлөөлж байгааг тайлбарла.

Ахлагч Ричард Ж. Скотт адил хичээлийг заасныг тайлбарла. Тэрээр үүнийг ажиглажээ: “Яг дунд нь зогсож байхад аль нь зөв, аль нь буруу мэдэхэд хэцүү байдаг. Тэрхүү дунд хэсэг нь Сатаны зөв шударга хүмүүсийг унагахын тулд ажилладаг хэсэг юм. ... Тэнд төөрөлдөхөд амархан байдаг. Их Эзэний тогтоосон сайн сайхны тэр гайхамшигт хэсэгт амьдар. Тэгснээр та уруу таталтын асуудалд орохгүй байх болно. Хэрэв танд ямар нэгэн зүйлийг үзэж, харж, сонсож, бодож, хийхэд тохиромжгүй мөн зохисгүй мэт санагдвал битгий хий. Та Сатаны урхинд орж мэднэ.” (“Do What Is Right,” *Ensign*, 1997 оны 6-р сар, 53–54).

Энэ үзүүлэнт хичээл нь гэр бүлийн гишүүдийн өдөр тутам тулгардаг уруу таталт болон шийдвэрүүдтэй хэрхэн холбогдож байгааг ярилц.

“Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүл”

11

2 Нифай 31–33

- Нифай өөрийн хамгийн сүүлийн бичиглэлийг “Христийн сургаалын талаар миний ярих ёстой үгс” (2 Нифай 31:2) хэмээн эхлүүлсэн байдаг. 2 Нифай 31-р бүлэг дэх Нифайн заасан зүйлс дээр үндэслэн та “Христийн сургаал” гэдгийг юу гэж тайлбарлах вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлдээ зориулж оройн хоолны ширээ засаад та тэдний хоолыг зөөж өгөх болно гэж хэл. Тэднийг ширээндээ суусны дараа тэдний

иддэг хэмжээнээс бага хэмжээний хоолыг авчирч өг. Тэгээд дараах ярилцлагыг өрнүүл:

- Хэрхэн бага хэмжээний хоол идэхийг зарим тохиолдолд судраас суралцахтай харьцуулж болох вэ?
- Гэр бүлээрээ 2 Нифай 32:3-г унш. “Христийн үгэн дээр найрла” (2 Нифай 32:3) гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Бид хувиараа болон гэр бүлээрээ судар дээр найрлахын тулд юу хийх вэ?

Иаков 1–4

Бошиглогч Иаковын талаар илүү ихийг суралцахын тулд дараах судруудыг унш: 1 Нифай 18:7; 2 Нифай 2:1–4; 6:2–4; Иаков 1:1–2, 18–19.

- Бошиглогч Иаков бардамнал, эд хөрөнгө, ёс бус явдал, атаа хорслын эсрэг биднийг анхааруулсан байдаг (Иаков 2:12–16, 22–23; 3:5, 9). Тэрээр өөрийн хүмүүсийг наманчлалд дуудсаны дараа Цагаатгалаас ирэх өршөөлийн найдварын талаар гэрчилж өөрийн үгсийг төгсгөсөн юм. Иаковын хэлсэн Христэд найдах найдварыг бид хэрхэн олж авч чадах вэ? (Иаков 4:4–12-г үз)

Иаков эхнэр, хүүхдүүдээ зүй ёсоор халамжлаагүй Нифайчуудын эрчүүдийг зэмлэсэн байдаг (Иаков 2:9, 31–32, 35). Мөн Хожмын Үеийн Сүмийн удирдагчид зүй бус харьцаа, хүчирхийллийн эсрэг хүчтэй

сануулгуудыг өгсөн юм. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулга ийнхүү анхааруулсан байдаг: “ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэгэн өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болно гэдгийг бид анхааруулж байна” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” *Ensign*, 1995 оны 11-р сар, 102).

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлийн гишүүдээр Иаков 2:35-г уншуул. Тэгээд дараах асуултуудыг асуу:

- Бусдын зүрх сэтгэлийг шархлуулах ямар үг эсвэл үйлдэл байж болох вэ? Бид гэр бүлдээ илүү их эв нэгдэл, хайрыг авчрахын тулд юу хийж болох вэ?

Чидун модны ёгтлол

Иаков 5–7

Иаков 5-р бүлэг нь Мормоны Номонд нэг бус удаа гардаг Еврей бошиглогч Зиносын ёгтлолыг агуулсан байдаг. Ёгтлол гэдэг нь ямар нэгэн зүйл буюу үйл явдал нөгөөгөө дүрсэлж эсвэл төлөөлөхийг хэлдэг. Дараах хүснэгт ёгтлолын талаар илүү сайн ойлгоход туслах болно:

Билэг тэмдэг	Утга
Талбай	Дэлхий
Талбайн эзэн	Есүс Христ

Бэлэг тэмдэг	Утга
Чидуны таримал мод	Израилын угсаа, Их Эзэний гэрээт хүмүүс
Зэрлэг чидуны мод	Харийнхан (Израилын угсаанд төрөөгүй хүмүүс)
Мөчрүүд	Бүлэг хүмүүс

Билэг тэмдэг	Утга
Зарц	Бошиглогч болон үйлчлэхээр дуудагдсан бусад хүмүүс
Жимс	Хүмүүсийн амьдрал эсвэл ажил хөдөлмөр

Гэр бүлийн үдшийн санаанууд

Иаков 5:61–72-г дурдсан зарц нар нь сайн мэдээг хуваалцаж буй Хожмын Үеийн Гэгээнтнүүд гэдгийг тайлбарла (С ба Г 133:8). Гэр бүлийн гишүүд бүрэн цагийн номлогчийн хувьд эсвэл гишүүн номлогчийн хувьд өдөр бүрийн үйлдэлдээ сайн мэдээг хуваалцаж болох арга замуудыг ярилц. Номлолын ажилд гэр бүлийн гишүүдийг илүү сайн бэлтгэхэд туслах зорилгуудыг тавь.

“Мэргэн зорилгын улмаас”

14

Инос, Жером, Омнай, Мормоны үгс

- Инос Их Эзэнд хандсан өөрийн залбирлыг хэрхэн дүрсэлсэн бэ? (Инос 1:2-г үз) Тэрээр өршөөлийг эрэлхийлж байгаа нь танд наманчлалын талаар юу зааж байна вэ? Мөн энэ шүлэг танд залбирлын талаар юу зааж байна вэ?
- Бид хэрхэн “[өөрсдийн] бүхэл бодгалийг [Аврагчид] өргөл болгон өгөх” (Омнай 1:26) вэ?
- Мормон өөрийн хураангуйлсан ариун нандин цэдгүүдийн зорилгыг юу гэж хэлсэн бэ? (Мормоны Үгс 1:2, 8 мөн Мормоны Номын нүүр хуудсыг үз) Мормоны Номыг зорилготой унших нь яагаад чухал вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Инос, Жером, Омнай номнуудыг бичиглэсэн хүмүүс өөрсдийн хүмүүсийн бичиглэлийг хадгалан үлдээж, нэмж бичихээр зарлигдуулсан гэдгийг тайлбарла. Мөн Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд өөрсдийн болон гэр бүлийнхээ түүхийг бичиглэхийг зөвлөсөн билээ. Хэрэв танд өвөг дээдсийн тань тэмдэглэл эсвэл бичиглэл байгаа бол гэр бүлээрээ зарим хэсгээс нь унш. Хувийн болон гэр бүлийн тэмдэглэл хөтлөхийн ач холбогдлыг ярилц.

“Тэнгэрлэг Эцэгтээ өгөх мөнхийн өр”

15

Мозая 1–3

- Судруудыг судалдаг Нифайчууд болон судруудыг судалдаггүй Леменчүүдийн хооронд Хаан Бенжамины хаанчлалын үед ямар ялгаа байсан бэ? (Мозая 1:5-г үз) Тэдгээр ялгаанууд одоогийн нийгэмтэй хэрхэн холбогдож байна вэ?
- Мозая 2:20–21, 34-г унш. “Тэнгэрлэг Эцэгтээ өгөх мөнхийн өртэй” “ашиггүй зарц нар” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Яагаад бид түүнд өөрсдийн бүхий л бие сэтгэлээрээ үйлчилж, түүнийг магтан дуулсан ч Бурханы хувьд ашиггүй

зарц нар хэвээрээ байдаг вэ? (Мозая 2:22–25 мөн уг хуудасны хавсралт материалыг үз) Энэ нь таныг хайрлах Тэнгэрлэг Эцэгийн хайрын талаар юу зааж байна вэ?

- Та Мозая 2–3-аас Есүс Христийн Цагаатгалын талаар юу сурч байна вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Зургийг харж цаасан дээр жинлүүр зур.

Гэр бүлийн гишүүдээс яагаад энэ жинлүүр тэнцүү биш байгааг асуу. Тэгээд тэднээр Мозая 2:20–25-г чангаар уншуул. Унших зуураа бидний Их Эзэнд өгч болох өргөлүүд болон Түүний бидэнд өгдөг адислалуудыг эрж ол. *Бидний өргөлүүд* гэсэн бичигтэй жинлүүрийн хажууд



өөрсдийнхөө өргөлүүдийг жагсааж бич. *Бурханы адислалууд* гэсэн бичигтэй жинлүүрийн хажууд Бурханы адислалуудыг жагсааж бич. Бид үргэлж түүнд өртэй байх болно гэдгийг ойлгоход нь гэр бүлийн гишүүдэд тусал. Бурханы адислалуудад талархлаа илэрхийл.

“Та нар Христийн хүүхдүүд гэж нэрлэгдэх болно”

16

Мозая 4–6

- Хаан Бенжамин яагаад өөрсдийн хүмүүсийг “юу ч биш”, ашиггүй гэж тодорхойлсон бэ? (Мозая 4:5–8, 11–12-г үз) Бид Их Эзэнээс хамааралтай гэдгээ санах нь яагаад чухал байдаг вэ?
- Хаан Бенжамин хэлсэнчлэн эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ өмнө ямар үүрэг хариуцлагуудыг хүлэсэн байдаг вэ? (Мозая 4:14–15-г үз)
- Хаан Бенжамин гачигдалтай хүмүүсийг халамжлахыг өөрийн хүмүүст сургасан байдаг (Мозая 4:16–17, 22). Хэрэв гачигдагсад туслахаас татгалзвал бид яагаад “наманчлах агуу шалтгаантай” болдог вэ? (Мозая 4:18–23-г үз) Бид бүгд гуйлгачид гэдэг нь юу гэсэн үг вэ? (Мозая 4:19–20-г үз)
- Хаан Бенжамин шар наран бор хоногийг хоолтой өнгөрөөх ядууст юу гэж зөвлөсөн бэ? (Мозая 4:24–25-г үз) Та өөрийн санхүүгийн байдлыг харгалзахгүйгээр хэрхэн өглөгч сэтгэлийг хөгжүүлэх вэ?
- Хаан Бенжамин нүглээс зайлсхийж, Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, бодол, үгс, үйлээ хянахыг өөрийн хүмүүст заадаг (Мозая 4:29–30). Бодол, үгс, үйл гурав хоорондоо хэрхэн холбогдох вэ?
- Хаан Бенжамин ярихад Их Эзэний Сүнс тэдэнд хэрхэн нөлөөлсөн бэ? (Мозая 5:2–5-г үз) Хэрэв бид “хилэнцийг үйлдэх хүсэлгүй” болвол бидний амьдрал,

бусадтай харилцах харьцаа хэрхэн өөрчлөгдөх вэ?

- Христийн хүүхдүүд болох гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Мозая 5:2, 5–7-г үз) “Христийн нэрийг [өөрсөд дээрээ] авах” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Мозая 5:8–11-г үз) Христийн нэрийг зүрх сэтгэлдээ бичээстэй нь хадгалахын тулд та өдөр бүр юу хийж чадах вэ? (Мозая 5:11–15-г үз)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлээрээ Мозая 4:16–27-г унш. Тусламж хэрэгтэй хүмүүст туслахын тулд хамтдаа хийж болох зүйлсийн талаар ярилц. Та үйлчлэл хийх төлөвлөгөө гаргаж болно. Мөн мацгийн өргөл болон тэдгээр нь хэрхэн зарцуулагддаг талаар ярилцаж болно.

“Үзмэрч ... бусдадаа агуу ашиг тус хүргэх бөлгөө”

17

Мозая 7–11

Та Мозая 7–11-р бүлгийг судлахдаа бошиглогч, үзмэрч, илчлэгч хэмээн Их Эзэнээр дуудагдсан тэдгээр хүмүүсийн удирдамжийг дагахын чухлыг зааж буй шүлгүүдээс ол.

- Аммон үзмэрчийн үүргийг хэрхэн дүрсэлсэн бэ? (Мозая 8:16–18-г үз) Абинадай үзмэрчийн үүргийг хэрхэн биелүүсэн бэ? (Мозая 11-р бүлэг дэх тодорхой жишээнүүдийг ол)

Заримдаа бид адил нөхцөлд буй хоёр хүний ялгааг олж харснаар нэмэлт ойлголтыг судраас авч болдог. Хаан Ноаг Хаан Бенжаминтай харьцуулахын тулд дараах хүснэгтийг ашигла.

Хаан Ноа	Хаан Бенжамин
Мозая 11:2	Мозая 2:13
Мозая 11:3–4, 6	Мозая 2:12, 14
Мозая 11:5, 7	Мормоны Үгс 1:17–18

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд бол бошиглогч, үзмэрч, илчлэгч гэдгийг тайлбарла. Хожмын үеийн бошиглогч, үзмэрч, илчлэгчид бидэнд хэрхэн “агуу ашиг тус” хүргэдгийг ярилц (Мозая 8:16–18). Сүмийн Ерөнхийлөгчийн сүүлийн чуулган дээр өгсөн яриаг унш.

“Бурхан өөрөө ... өөрийн хүмүүсийг гэтэлгэх болно”

18

Мозая 12–17

Та Мозая 12–17-р бүлгийг судлахдаа Хаан Ноа болон түүний санваартнуудад хүргэсэн Абинадайн захиасыг

эрж ол. Абинадай тэрхүү захиасыг хүргэхийн тулд амиа өгөхөд ч бэлэн байсан шалтгааныг өөрөөсөө асуу.

- Абинадай “түүнийг буруутгах” гэсэн санваартнуудын оролдлогыг давж гарсны дараа нэг санваартан түүнээс судрын эшлэлийн талаар асуулт асуудаг (Мозая 12:19–24 мөн Исаиа 52:7–10-г үз). Санваартнууд яагаад энэ судрын эшлэлийг ойлгох боломжгүй байсан бэ? (Мозая 12:25–27-г үз) Ойлгохын тулд зүрх сэтгэлээ зориулна гэдэг нь юу гэсэн үг вэ?
- Зарлигуудыг “[өөрсдийн] зүрх сэтгэлд бичнэ” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Мозая 13:11). Зарлигуудыг зүрх сэтгэлдээ хадгалах нь тэдгээрийг дагах таны хичээл зүтгэлд хэрхэн нөлөөлөх вэ?
- Мозая 14-р бүлэгт эш татсан бошиглоос та Аврагчийн талаар юу сурсан бэ?
- Абинадай өөрийн бошиглолын эцэст Хаан Ноа болон түүний

санваартнуудыг юу хий гэж ухуулсан бэ? (Мозая 16:13–15-г үз) Та энэ зөвлөгөөг хэрхэн амьдралдаа хэрэгжүүлж болох вэ?

- Хэдийгээр та итгэлийнхээ төлөө үхэх шаардлагагүй ч ямар замаар Абинадайн үлгэр жишээг дагаж болох вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Есүс Христийн Цагаатгалын талаарх захиасыг аюултай нөхцөл байдалд тунхаглаж байсан Абинадай шиг хүмүүсийг гэр бүлээрээ жагсааж бич (жишээлбэл, Үйлс 4:1–12; 1 Нифай 1:18–20; Мозая 18:1–2; Хиламан 13:1–7-г үз). Хэрэв танай гэр бүлд номлолын ажлыг хүнд нөхцөл байдалд хийж байсан хэн нэгэн байвал тэдний олж авсан туршлагын талаар ярилц. Тэдгээр туршлагуудыг дэвтэртээ тэмдэглэж авахыг гэр бүлийн гишүүдээс хүс.

“Их Эзэнээс өөр хэн ч тэднийг чөлөөлж чадахгүй”

19

Мозая 18–24

Мозая 18-р бүлэг баптисмын гэрээний тайлбарыг агуулдаг. Энэ бүлгийг судлахаасаа өмнө Бошиглогч Иосеф Фиелдинг Смитийн хэлсэн дараах үгсийг унш:

“Тэрээ бол Тэнгэрт буй Их Эзэн, дэлхийд буй хүн хоёрын хоорондын зөвшилцөл юм. Хүн зарлигуудыг дагана гэж зөвшөөрсөн бол Их Эзэн тэднийг дуулгавартай байдлынх нь дагуу шагнана гэж амласан.” (in Conference Report, 1970 оны 10-р сар, 91; эсвэл *Improvement Era*, 1970 оны 12-р сар, 26).

- Бид баптисм хүртэхдээ юу хийнэ гэж гэрээ хийдэг вэ? (Мозая

18:8–13; Моронай 6:2–3; С ба Г 20:37-г үз) Бид баптисм хүртэж, баптисмын гэрээгээ сахих юм бол Их Эзэн юу хийнэ гэж бидэнд амласан бэ? (Мозая 18:10, 12–13; 2 Нифай 31:17-г үз)

- Их Эзэн Алмагийн хүмүүсийг боолчлолд байхад нь яагаад Лимхайн хүмүүсээс илүү хурдан, илүү ихээр адисалсан бэ? (Мозая 21:5–15-г Мозая 23:26–27; 24:10–16-тай харьцуул) Энэ нь бидний амьдралд хэрхэн холбогдож байна вэ?
- Бид “баяртайгаар мөн тэвчээртэйгээр Их Эзэний бүх тааллуудад

захирагдахад” бидний ачаа дарамт хөнгөлөгддөг шалтгаан нь юу вэ? (Мозая 24:15). Их Эзэн та нарыг “ачаагаа амархан дааж чадахын тулд” ямар арга замаар хүчирхэг-жүүлдэг вэ?

- Нүглийн боочлолоос чөлөөлөгдөх талаар бид Лимхай болон Алмагийн хүмүүсээс юу сурч

болох вэ? (Мозая 7:33; 21:14; 23:23; 29:18–20; С ба Г 84:49–51-г үз)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Өмнөх хуудсан дээрх баптисмын гэрээний талаарх асуултуудыг ярилц. Баптисм хүртсэн гэр бүлийн гишүүдийг баптисмынхаа талаар ярихыг урь.

“Бодгаль минь цаашид дахин өвдөх нь үгүй”

20

Мозая 25–28; Алма 36

Мозая 25–28 мөн Алма 36-р бүлэг нь Алма болон Мозаягийн хөвгүүдийн гайхамшигт хөрвөлтийн талаар өгүүлдэг. Та эдгээр бүлгүүдийг судлахдаа өөрийнхөө хөрвөлтийн талаар бодох цаг гаргаарай.

- “Нэг нэгнийхээ алдаануудыг уучлах нь” яагаад чухал вэ? (Мозая 26:31). Хэн нэгнийг уучлах эсвэл хэн нэгнээр уучлагдсанаар та хэрхэн адислагдсан бэ?
- Их Эзэн яагаад залуу Алма болон түүний нөхөд рүү тэнгэр элчийг явуулсан бэ? (Мозая 27:14-г үз) Бидний хайртай хэн нэгэн сайн мэдээний замаас холдох үед залбирал бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Мозая 27 болон Алма 36-р бүлэгт гарч буй Алмагийн уучлагдсаны өмнөх болон дараах мэдрэмжийг тодорхойлсон үг болон эшлэлүүдийг тэмдэглэж ав. (Жишээлбэл, Мозая 27:29-г үз. Алма уучлагдахын өмнө түүний “бодгаль мөнхийн зовлонд тарчилж байв”. Харин тэрээр

уучлагдсаны дараа түүний “бодгаль цаашид дахин өвд[сөнгүй]”.)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Дараах асуултуудыг гэр бүлийнхнээсээ асуу:

- Номлолд үйлчлэхээр бэлтгэж байгаа хүний хувьд хамгийн чухал анхаарах ёстой зүйлс юу вэ? (Бидний хаана үйлчилж байгаа нь бид яагаад үйлчилж байгаа мөн хэрхэн үйлчилж байгаатай адил чухал биш гэдгийг ойлгоход нь гэр бүлийн гишүүдэд тусал.)

Гэр бүлийн гишүүдийг Мозая 8-р бүлэг рүү эргэж очихыг хүс. Энэ бүлэг нь Леменчүүдийн дунд үйлчлэх хүсэлтэй байгаа Мозаягийн хүүгийн талаарх цэдгийг агуулсан гэдгийг тайлбарла.

- Яагаад Мозаягийн хүү Леменчүүдэд номлохыг хүссэн бэ? (Мозая 28:2–3-г үз) Бид хэрхэн сайн мэдээг хуваалцах амлалтаа илүү сайн биелүүлэх вэ?

Мозая 29; Алма 1–4

Хаан Мозаягийн бүх хөвгүүд хаан болохоос таггалздаг. Мозая хүмүүсийн дунд бичиглэгдсэн үгийг илгээдэг. Тэрээр хаант засаглалын оронд шүүгчдийн засаглалыг санал болгодог. Та Мозая 29-р бүлгийг судлахдаа Хаан Мозаягийн үгс “хүмүүсийн амар амгаланг тогтоох зүйл хийхэд” (Mosiah 29:10) тусалдаг удирдагч нарын талаар юу зааж байгааг тунгаан бод.

- Шүүгчдийн засаглалын эхний жилд Нихор нэртэй нэгэн эр Алмагийн өмнө шүүгдэхээр авчрагддаг (Алма 1:1–2, 15). Нихор хүмүүст юу зааж байсан бэ? (Алма 1:3–4-г үз) Түүний сургаалын үр нөлөө нь юу байсан бэ? (Алма 1:5–6-г үз) Нихорын сургаал яагаад тийм олон хүнд тааламжит байсан юм бол? Өнөө үед та үүнтэй адил сургаалыг сонсож байсан уу?

- Хүмүүсийн бардамнал, алдсын эсрэг Алма ямар үйлдэл хийсэн бэ? (Алма 4:15–19-г үз) Бурханы үгийг номлох нь хэрхэн “тэдэнд үүргийг нь сануулахаар өдөөж” болох вэ? Бурханы үгийг номлох нь хэрхэн бардамнал, башир арга хийгээд тэмцлүүдийг “намжааж” болох вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлээрээ Алма 4:15–20-г унш. Тэгээд дараах асуултуудыг асуу:

- “Тэдний эсрэг шударга гэрчлэлийг үзүүлэхээс бусдаар” хүмүүст туслах өөр замыг Алма хараагүйн шалтгаан нь юу вэ? Дэлхий дээр өнөөдөр ямар асуудлуудыг сайн мэдээг зааж, түүний дагуу амьдарснаар даван туулж болох вэ?

“Та нар түүний дүр төрхийг царай төрхөндөө хүлээж авсан уу?”

Алма 5–7

Алма 5-р бүлэг нь 40 гаруй асуултуудыг багтаадаг. Тэдгээр асуултуудыг олж, хэрхэн хариулахаа тунгаан бод.

- Зарахемлагийн хүмүүст хийх номлолынхоо турш Алма зүрх сэтгэлийн “хүчит өөрчлөлтийг” эдэлж, “Бурханаар төрөх” (Алма 5:14) тухай бошиглодог. Бид энэхүү туршлагын тухай ярихдаа ихэвчлэн *хөрвөлт* гэдэг үгийг ашигладаг. *Хөрвөсөн* гэдэг нь юу гэсэн үг вэ? (Мозая 5:2; 27:24–26-г үз)

Гэр бүлийн үдшийн санаанууд

Алма 5:14, 19-г гэр бүлээрээ унш. *Царай төрх* гэдэг үг нь хүний зан араншин эсвэл зан байдлаа илэрхийлж байгаа байдлыг төлөөлж байгааг тайлбарла.

- “Бурханы дүр төрхийг [өөрсдийн] царай төрхөндөө хүлээж авна” гэдэг нь юу гэсэн үг вэ? “[Өөрсдийн] царай төрхөндөө түүний дүр төрхийг хүлээж авсан” ямар шинжийг та бусад хүмүүсээс харж байсан бэ?

Алма 8–12

- Гидеон болон Мелекийн хүмүүсийн дунд сүмийн жаягийг үндэслэснийхээ дараа Алма Аммонайха руу номлохоор явдаг. Тэрээр Аммонайхад ямар сорилт бэрхшээлүүдийг туулсан бэ? (Алма 8:8–9-г үз)
- Алма 8:10-р шүлэгний ямар үг Аммонайха дахь Алмагийн хичээл зүтгэлийн хүчийг харуулж байна вэ? Аммонайхагийн хүмүүс Алмагийн номлолд хэрхэн хандсан бэ? (Алма 8:11–13-г үз)

Та Алма 8:18–32 болон Алма 10–11-г судлахдаа тэнгэр элчийн захиасыг дуулгавартай дагаж, Алмагийн хамтрагч болон үйлчилснээр Амюлек хэрхэн өөрчлөгдсөнийг бодож ол.

- Бидний зүрх сэтгэлийн байдал Бурханы үгийг ойлгоход хэрхэн нөлөөлөх вэ? (Алма 12:9–11-г үз) Бид Бурханы үгийг ойлгож, хүлээж авч, таньдаг зүрх сэтгэлийг хэрхэн бий болгох вэ? (1 Нифай 2:16; 15:11-г үз)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд
Алма ганцаараа Аммонайхад ирэхэд хүмүүс “Нэг хүнээс илүүд эрх мэдэлтнийг үл илгээгч, Бурхан гэгч

хэн бэ?” гэж асуусныг тайлбарла (Алма 9:6). Амюлекийг тэдэнд номлоход “нэгэн гэрчээс илүү нэгэн байсны учир” (Алма 10:12) хүмүүс гайхширч эхлэв. Гэр бүлээрээ дараах хүснэгтэнд буй судруудыг унш. Алма, Амюлек хоёр хэрхэн адил сургаалыг номлож бие биеийнхээ хичээл зүтгэлийг дэмжиж байсныг тэмдэглэ:

Сургаал	Амюлекийн гэрч	Алмагийн гэрч
Цагаатгал	Алма 11:40	Алма 12:33–34
Наманчлал	Алма 11:40	Алма 12:24
Шүүлт	Алма 11:41	Алма 12:14
Амилуулалт	Алма 11:41–42	Алма 12:24–25

- Сайн мэдээг хуваалцахад нэгээс илүү гэрч байх нь ямар давуу талтай вэ? Бид бие биеэ хэрхэн дэмжиж болох вэ?

“Христэд итгэх бидний итгэлийн дагуу бидэнд хүчийг өгөөч”

Алма 13–16

Алма Зиезром болон Аммонайха дахь бусад хүмүүст гэтэлгэлийн төлөвлөгөөний талаар заасныхаа дараа санваар болон урьдчилсан томилолтын сургаалын талаар

гэрчилдэг. Алма 13:1–7-той холбогдолтой дараах эшлэлүүдийг унш: Бошиглогч Иосеф Смит “Дэлхийн оршин суугчдад үйлчлэхээр

дуудагдсан хүн бүр өмнөх амьдралд тэнгэрт Их Зөвлөгөөн дээр энэхүү зорилгыг хэрэгжүүлэхээр томилогдсон байдаг” (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 365) хэмээн хэлжээ.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл ийн заадаг: “Энэ дэлхийд ирэхээс өмнө итгэлтэй эмэгтэйчүүдэд тодорхой үүрэг даалгаврууд өгөгдсөн ба итгэлтэй эрэгтэйчүүд санваарын тодорхой үүрэгт урьдчилан томилогдсон байдаг. Бид эдгээр үйл явдлуудыг санадаггүй ч энэ нь бидний хүлээн зөвшөөрсөн үнэн бодит байдлыг өөрчилж чадахгүй юм. Бошиглогч, төлөөлөгч хэмээн бидний дэмждэг тэдгээр хүмүүсийн адил таныг тэнгэрт байхад томилсон бөгөөд та тэдгээр үүргийнхээ төлөө хариуцлага хүлээдэг билээ!” (“The Role of Righteous Women,” *Ensign*, 1979 оны 11-р сар, 102).

- Алма, Амюлек хоёр шоронд олон өдрийн турш хоригдсоны дараа

хэрхэн шоронгоос чөлөөлөгдсөн бэ? (Алма 14:26–29; Ифер 12:12–13-г үз) Бид өөрсдийгөө юунаас чөлөөлөх ёстой вэ? Чөлөөгдөхийн тулд бидний итгэл яагаад Христэд төвлөрсөн байх ёстой вэ? (Мозая 3:17; Моронай 7:33-г үз)

- Алма 15:3–5-р шүлэг Зиезромын Алма, Амюлек хоёрт итгэх итгэлийн талаар юу хэлж байна вэ? Зиезром эдгээгдэхийн тулд хэнд итгэлээ тавих хэрэгтэй байсан бэ? (Алма 15:6–10-г үз) Зиезромын эдгээгдсэнийх нь дараах үйлдлээс та юу сурч байна вэ? (Алма 15:11–12-г үз)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Алма 13–16-р бүлгийг бүхэлд нь уншсаны дараа гэр бүлийн гишүүдээс сурсан зүйлсээ хуваалцахыг хүс.

“Тэд Бурханаас хүлээн авсан хүч мөн эрх мэдэлтэйгээр зааж байв”

25

Алма 17–22

- Леменчүүдийг үнэний мэдлэгт авчрахад их амжилт гаргахад Аммон болон түүний ах дүү нарт юу тусалсан бэ? Аммон болон Аароны номлолын ажилд хандах хандлагаас та юу сурч байна вэ?
- Аммон, Аарон хоёр Хаан Лемонай болон түүний аавд ямар сургаал заасан бэ? (Алма 18:34–39; үз)
- Бурханы мэдлэгт ирэхийн тулд Лемонайн эцэг юуг золиослоход бэлэн байсан бэ? (Алма 2:15,

17–18-г үз) Та түүний жишээнээс юу сурч болох вэ?

Та Алма 17–22-г уншихдаа зовлон бэрхшээлийг даван туулсны дараа адислалыг хүлээн авсан хүмүүсийн түүхийг ол. Сорилт бэрхшээлийг итгэлтэйгээр даван туулсны дараа ирсэн адислалуудаа тунгаан бод.

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Хэд хэдэн багаж, төхөөрөмж гаргаж тавь. Гэр бүлийн гишүүдээс эдгээрийг юунд хэрэглэдгийг асуу. Тэгээд Алма 17:1–9-г уншиж, бид сайн

мэдээг бусадтай хуваалцсанаар Мозаягийн хүү шиг “Бурханы мутарт зэмсэг” болж чадна гэдгийг

онцлон тэмдэглэ. Бид Түүний мутарт зэмсэг болохыг хичээх үед Их Эзэн бидэнд тусална гэдгийг тайлбарла.

“Их Эзэнд хөрвүүлэгдсэн”

Алма 23–29

Алма 23–27-р бүлэгт “хэзээ ч итгэл алдраагүй” (Алма 23:6) гүн гүнзгий хөрвөсөн Антай-Нифай-Лихайчууд хэмээн нэрлэгдсэн хэсэг бүлэг хүмүүсийн талаар гардаг. Та энэ түүхийг судлахдаа үнэн болон Антай-Нифай-Лихайчуудын хөрвөлтийг баталсан үйл явдлуудыг эрж ол.

- Антай-Нифай-Лихайчууд “Их Эзэнд хөрвүүлэгдсэн” (Алма 23:6). Есүс Христийг хөрвөлтийнхөө төв болгох нь яагаад чухал вэ?
- Хөрвөсөн Леменчүүд өөрсдийгөө ёс бус ах дүүсээсээ тусгаарлахыг сонгодог (Алма 23:16–18; 27:27–30.) Бид хөрвөснийхөө дараа дэлхийгээс хэрхэн тусгаарлагддаг вэ?
- Антай-Нифай-Лихайчууд зовлон зүдгүүрээсээ гадна юунд талархалтай байсан бэ? (Алма 24:7–10-г үз) Бурханд талархалтай байх нь зовлон бэрхшээлийг даван туулахад бидэнд хэрхэн тусалдаг вэ?

- Антай-Нифай-Лихайчууд “зэр зэвсгээ авч ... мөн тэдгээрийг газрын гүнд булшлав” (Алма 24:15–17). Тэдгээр зэвсгийг дахин хэрэглэхгүй гэж зүгээр л амлалт өгснөөс газарт булшлах нь яагаад чухал байсан бэ? Бид “эсэргүүцлийн зэр зэвсгээ” булслахын тулд юу хийж болох вэ?

Та Алма 26–27-р бүлгийг судлахдаа хичээл зүтгэлийнх нь үр дүнд номлогч нарт ирсэн адислалуудын жишээг эрж ол.

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Антай-Нифай-Лихайчуудын хөрвөлтийн талаарх түүхийг ярьж өг. Ярилцлагыг эхлүүлэхийн тулд энэ хэсэг дэх асуултуудаас ашигла. Тэгээд гэр бүлийн гишүүдээр хөрвөлтийн талаарх дараах судруудыг уншуул:

Лук 22:32

Мозая 5:2

Мозая 5:7

Алма 5:7–14

3 Нифай 6:14

3 Нифай 9:13–14

“Бүх зүйл нь Бурхан байдгийг гэрчилдэг”

Алма 30–31

Алма 30–31-г судлахдаа Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсонгийн хэлсэн дараах үгийг оюун бодолдоо тунгаа:

“Мормоны Ном Христийн дайснуудыг илрүүлдэг. ... Мормоны Номонд гардаг урвагчид өнөөдрийн дэлхийн урвагч хүмүүстэй адил юм. Бид өнөө

үеийн боловсрол, улс төр, шашин, гүн ухааны буруу бодлого, үзэл санаатай хэрхэн тэмцэхийг мэдэж болохын тулд Бурхан өөрийн хязгааргүй зөгнөх мэдлэгийн дагуу Мормоны Номыг бүтээсэн билээ.” (“The Book of Mormon Is the Word of God,” *Ensign*, 1988 оны 1-р сар, 3).

- Корихор Бурхан байдгийг батлах тэмдэг шаардахад Алма Бурхан амьд гэдгийг нотлох жишээнүүдийг хуваалцдаг? (Алма 30:44-г үз) Тэдгээр жишээнүүд таны итгэлийг хэрхэн хүчирхэгжүүлж байна вэ?

Алма 31-р бүлгийг судлахдаа Зорамчуудын залбирлыг Алмагийн залбиралтай харьцуул. Та олсон ялгаануудаа тэмдэглэж болно.

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Корихорын сургаалтай адил зүйлсийг өнөө үед ч хүмүүс заадаг

гэдгийг тайлбарла. Тэгээд дараах асуултуудыг ярилц:

- Бидний итгэлийг устгахыг эрэлхийлж буй хүмүүсийн нөлөөллийг давж гарахын тулд бид юу хийж болох вэ? (Хариултууд нь судраас судлах; залбирах; зөрчилдөөнөөс зайлсхийх; эцэг эх, бишоп эсвэл итгэл даах найз нартайгаа ярилцаж болно)

“Авралд хүргэдэг үг Христэд буй”

28

Алма 32–35

- Алма Бурханы үгийг үртэй зүйрлэсэн байдаг (Алма 32:28). Та зүрх сэтгэлдээ Бурханы үгэнд “зай тавьж өгөхийн” тулд юу хийж болох вэ? (Алма 32:28).
- Алма 32:28–35-г унш. Үг “цээжинд өсөх” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Судрууд хэрхэн та нарын бодгалийг тэлж, ойлголтыг гэгээрүүлж, оюун санааг өргөжүүлдэг вэ? Бурханы үг та нарт хэрхэн амтат санагдсан бэ?
- Хүмүүс Алмагийн бошиглолыг сонссоны дараа “ямар маягаар тэд итгэлээ хөгжүүлж эхэлвэл зохи-хыг” (Алма 33:1) мэдэхийг хүсдэг. Алма бошиглогч Зинос, Зинок болон Мосегийн заасан зүйлсээс эш татан хариулдаг. Тэдгээр захиасуудын гол захиас нь юу байсан бэ? (Алма 33:3–22-г үз)

Алма 33:19–22-г уншсаныхаа дараа Тооллого 21:4–9, Иохан 3:1–16, 1 Нифай 17:41, Алма 37:46 мөн Хиламан 8:13–15-г унш. Эдгээр судруудыг хамтад нь уншсанаар илүү их ойлголтыг авч болох арга замыг хай.

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Бурханы үгийг зүрх сэтгэлдээ тарих тухай Алмагийн хэлсэн захиасыг тунгаан бодоход гэр бүлийнхэндээ туслахын тулд (Алма 32:28–43) гэр бүлийн гишүүн бүрд үр болон хөрс-тэй жижигхэн сав өг. Гэр бүлийн гишүүдээс үрээ суулгаж, түүнийгээ ус болон нарны цацрагаар тэжээж, арчлахыг хүс. Дараагийн хэдэн долоо хоногийн турш үр хэрхэн соёолж байгааг ажигла.

Алма 36–39

- Алма 36–39 нь Алмагийн хүү Хиламан, Шиблон, Кориантондоо өгсөн захиас буюу гэрчлэлийг агуулдаг. Эцэг эхийнхээ гэрчлэлийг сонсох нь хүүхдүүдэд яагаад чухал байдаг вэ? Таны эцэг эхийн гэрчлэл танд хэрхэн нөлөөлсөн бэ?

Эцэг эхчүүдийн хүүхдүүдэд өгдөг зөвлөгөөний ач холбогдлыг харуулсан дараах судрын эшлэлүүдийг унш:

Алма 36–39	Алма 57:21, 26–27
2 Нифай 1–3	Хиламан 5:5–14
Инос 1:1–3	С ба Г 68:25–28
Мозая 1:1–8	С ба Г 93:39–50
Алма 56:47–48	

- Алма 37:36–37-д гардаг зөвлөгөөг дагахыг хичээснээр таны амьдрал хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Кориантоны нүгэлт нөлөө бусдад хэрхэн нөлөөлсөн бэ? (Алма 39:11, 13-г үз) Сайн үлгэр жишээг үзүү-

лэх нь Сүмийн гишүүдэд яагаад чухал вэ? Таны гаргаж буй зан араншин бусдын Сүмийн талаарх үзэл бодолд хэрхэн нөлөөлөх вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлийн гишүүдийг Алма 37:6–7-г уншихыг хүс. Хадаас, эрэг боолт зэрэг ямар нэгэн юмыг хамтад нь холбодог жижиг зүйлийг харуул.

- Тэдгээр зүйлс хэр “өчүүхэн мөн энгийн” зүйл вэ? Эдгээр өчүүхэн зүйлс хэрхэн агуу зүйлийг бүтээхэд хэрэглэгдэж болох вэ? Бидэнд эдгээр зүйлс байхгүй бол юу болох вэ?
- Гэр бүлийг нэгдмэл байлгадаг “өчүүхэн мөн энгийн” зүйлс юу байдаг вэ? Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг болон бие биеэ хайрлах хайраа харуулахын тулд гэр бүлээрээ хийж болох “өчүүхэн мөн энгийн зүйлс” юу байдаг вэ?

“Аз жаргалын агуу төлөвлөгөө”

Алма 40–42

- Үхэл, амилуулалтын хооронд бидний сүнсэнд юу тохиолдох вэ? (Алма 40:11–15, 21; С ба Г 138-г үз)
- Хэрэв бид зөвхөн шударга ёсны хуулинд харьяалагдвал юу болох вэ? (Алма 42:14-г үз) Бид Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд эргэж очихын тулд шударга ёсны шаардлагыг хангахад юу шаардлагатай вэ? (Алма 42:15-г үз) Есүс Христийн Цагаатгал хэрхэн “шударга ёсны шаардлагыг хангасан” бэ? (Мозая 15:7–9-г үз) Бид Бурханы нигүүлслийг бүрэн дүүрэн хүлээн авахын

тулд юу хийх ёстой вэ? (Алма 42:13, 23, 27, 29–30; Алма 41:14; С ба Г 19:15–18-г үз)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлийн гишүүдэд Алма 42-р бүлгийг ойлгоход нь туслахын тулд *Сайн мэдээний зарчмууд* (31110) гарын авлагын 12-р бүлэгт гардаг Ахлагч Боид К.Пакерийн хэлсэн Зуучийн талаарх сургаалт үлгэрийг унш. Та өгүүлэл, зээлдүүлэгч, зээлдэгч болон зээлдэгчийн найзыг өөр өөр гэр бүлийн гишүүдээр уншуулж болно.

Алма 43–52

Алма 43–52 –р бүлэг нь дайны хэд хэдэн түүхүүдийг агуулдаг. Тэдгээр түүхүүд нь хэрхэн дэлхийн зөрчилдөөнийг даван туулж, Сатаны эсрэг тулалдаанд өөрийгөө болон гэр бүлээ хамгаалахыг бидэнд заадаг.

• Дайны цаг үед зөв шударга Нифайчуудын зан байдал, үйлдлийг удирдаж байсан дараах зарчмуудаас суралц. Эдгээр зарчмуудыг ойлгож, хэрэгжүүлэх нь өнөөдөр дэлхийд илүү агуу амар амгаланг авчрахад хэрхэн туслах вэ? Өөрийнхөө хувийн амьдралд тулгарч буй зөрчилдөөнийг даван туулахдаа та эдгээр зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

а. Өөрийгөө хамгаалах зэрэг зөвхөн зөв шударга учир шалтгааны төлөө тулалд (Алма 43:8–10, 29–30, 45–47; 48:14).

б. Дайснуудаа битгий үзэн яд; яг л өөр шигээ тэдний сайн сайхныг

эрэлхийл (Алма 43:53–54; 44:1–2, 6).

в. Зөв шударга амьдарч, Бурханд итгэ (Алма 44:3–4; 48:15, 19–20).

г. Зөв шударга, ухаалаг удирдагчдыг дага (Алма 43:16–19; 48:11–13, 17–19; С ба Г 98:10-г үз).

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Эрх чөлөөний тугийг өргөсөн ахмад Моронайн түүхийг унш (Алма 46:12–20). Тэгээд гэр бүлээрээ өөрсдийн эрх чөлөөний тугийг бүтээхийн тулд ажилла. Өөрсөд дээрээ Христийн нэрийг авч мөн Түүнийг санахад туслах хэдэн чухал зарчмыг жагсааж бичихийг гэр бүлийн гишүүдээс хүс. Тэгээд тэдгээр зарчмуудыг том цаасан дээр бич. Гэр бүлийн эрх чөлөөний туган дээрээ бичсэн тэдгээр зарчмуудын дагуу амьдрахад нь гэр бүлийн гишүүдийг дэмж.

“Тэд зарлигийн үг бүрийг яг таг гүйцэтгэхдээ дуулгавартай байв”

Алма 53–63

Та Алма 53 мөн Алма 56–58 –р бүлгийг судлахдаа 2060 залуу дайчдын дагасан зарчмуудыг болон бага залуудаа хөгжүүлсэн тэдний зан байдлыг эрж ол. Тэдгээр зарчмууд болон зан байдал залуу дайчдад Их Эзэнээс хүч чадал хүлээн авахад хэрхэн тусалсныг анхааралтай судал. Та тэдгээр зарчмуудыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг тодорхойл.

• Аммончуудын залуу дайчид тэрхүү агуу итгэл, зоригийг хэнээс

сурсан бэ? (Алма 56:47–48; Алма 53:21; 57:21-г үз) Эцэг эхийнхээ гэрчлэлийн хүч болон итгэлийг мэдэх нь хүүхдүүдэд яагаад чухал вэ?

Эх хүний талаарх дараах судруудыг судал:

Алма 56:47–48	1 Самуел 1:27–28
Эхлэл 24:60	Сургаалт үгс 1:8
Египетээс гарсан нь 20:12	Моисе 4:26

- Залуу Аммончууд бошиглогч Хиламаныг өөрсдийн удирдагч байхыг хүсэв (Алма 53:19; 56:1, 5). Тэд хүлээн авсан зарлиг тушаалдаа хэрхэн хандсан бэ? (Алма 57:21-г үз) Бошиглогчийг “яг таг” дагахын тулд таны хийх ёстой тодорхой хэдэн зүйлс юу вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд
Хиламаны 2060 залуу дайчдын түүхийг ярьж өг (Алма 53; 56–58). Тэгээд гэр бүлийн гишүүдээр дараах

жагсаасан судруудыг бүгдийг нь эсвэл заримыг нь уншуул. Эдгээр судрууд дээр заасан зарчмуудыг гэр бүлийн гишүүд хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилц.

Алма 53:20–21	Алма 57:25–27
Алма 56:45–48	Алма 58:6–11
Алма 57:21	Алма 58:39–40

Ярилцлагынхаа үеэр хамтдаа “We’ll Bring the World His Truth” (*Children’s Songbook*, 172) дууллыг дуулж болно.

“Бат бөх суурь”

Хиламан 1–5

Хиламан 1–4 нь Нифай болон Леменчүүдийн хоорондын зөрчилдөөн мөн энх тайвны цаг үеийг тодорхойлдог. Хиламан 5 нь Леменчүүд болон Нифайчуудын тэрслэгчдийн дунд хийгдсэн гайхамшигт номлолын ажлыг өгүүлдэг. Түүхийг судлахдаа эдгээр нь өнөө үетэй хэрхэн холбогдож байгааг олж тогтоо.

- Христийн даруу дагалдагчид хэрхэн мөрдлөг хавчлагыг даван туулж байсан бэ? (Хиламан 3:33–35-г үз) Тэдний үлгэр жишээ танд хэрхэн туслах вэ?
- Хиламан 5:12-г унш. Христийн хадан дээр барьж босгоно гэдэг нь юу гэсэн үг вэ? (3 Нифай 14:24–27-г үз)

Мормоны Номонд бараг 240 удаа санах гэдэг үг давтагдсан байдаг

33

(*санасаар байдаг, санав, санамж эсвэл бүү март гэх мэт*). Хиламан 5-р бүлэгт гарч буй 15 санах гэдэг үг эсвэл санах гэдэг үгийн ямар нэг хэлбэрийг ол. Ингэх зуураа яагаад санах гэдэг үг Их Эзэний гэрээт хүмүүст чухал болохыг тунгаан бод.

Та мөн санах гэдэг үг эсвэл санах гэдэг үгийн ямар нэгэн хэлбэрийг оролцуулсан судрын эшлэлийг хайхдаа Судрын удирдамжийг ашиглаж болно.

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Хиламан 5:12-г чанга унш. Тэгээд Есүс Христийн хадан дээр сууриа барих арга замуудыг ярилц.

Ярилцлагын дундуур “Бат бөх суурь” (*Hymns*, no. 85) дууллыг дуулж болно.

Хиламан 6–12

Хиламан 6–12-р бүлэгт гардаг түүхүүд бардамналын нүгэл хэрхэн хүмүүст нөлөөлж байгааг харуулдаг. Та энэ судрыг судлахдаа гэр бүлийн ярилцлагын санаанд байгаа тойргийг хар.

- Хиламан 12:7-г унш. Ямар учир шалтгаанаар Мормон тийн хэлсэн бэ? (Хиламан 12:1–6, 8-г үз)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Доорх схемийг цаасан дээр зур:



Энэхүү тойргийн дагуу явсан хэд хэдэн хүний жишээ Мормоны Номонд байдгийг тайлбарла.

- Хүмүүс хэрхэн энэ тойргоос гарч болох вэ? (Гэр бүлийн гишүүдээр Алма 62:48–51; Хиламан 12:23–24-г уншуул)

Цаасан дээр байгаа *Бардамнал болон ёс бус байдал* мөн *Сүйрэл болон зовлон зүдгүүрийн* дагуу зураас тат. Бид Нифайчуудын алдаанаас суралцаж болно гэдгийг хэл. Бид хөгжиж дэвшиж байх үедээ ч Их Эзэнийг үргэлж даруухнаар мөн талархалтайгаар санаж чадна.

Хиламан 13–16

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон ийн хэлсэн билээ: “Христийн ирэлтийн өмнөх Нифайчуудын түүхийн бичиглэл нь Аврагчийн хоёр дахь ирэлтийг хүлээн суугаа бидэнтэй олон талаар холбогддог.” (in Conference Report, Apr. 1987, 3; эсвэл *Ensign*, 1987 оны 5-р сар, 4).

Дараах хүснэгт Хиламан 13–16-р бүлэг нь Есүс Христийн хоёр дахь ирэлтийн өмнө тохиох үйл явдал, тэмдгүүдтэй холбоотой бошиглолыг агуулж байгааг харуулж байна.

Хиламан 13–16-р бүлэгт бичиглэгдсэн бошиглолууд болон үйл явдлууд	Бошиглол эсвэл үйл явдал	Хоёр дахь ирэлтийн өмнө тохиох үйл явдлууд болон тэмдгүүд
Хиламан 16:1, 3, 6, 10	Хүчит зөв шударга хүмүүс тоогоороо цөөн байв	1 Нифай 14:12; Иаков 5:70
Хиламан 16:13–14	Сүнсний цутгалт буюу сүнслэг гайхамшиг	Иоел 2:28–30; С ба Г 45:39–42
Хиламан 13:22; 16:12, 22–23	Агуу ёс бус байдал	2 Тимот 3:1–5; С ба Г 45:27
Хиламан 13:2, 6, 8, 10–11; 14:9, 11; 15:1–3, 17; 16:2	Их Эзэний бошиглогчдыг эсэргүүцсэн нь мөн наманчлалд дуудах тэдний урилга	С ба Г 1:14–16
Хиламан 14:3–4	Гэрэлтэй үдшийн тухай бошиглол	Зехариа 14:7 мөн <i>Teachings of the Prophet Joseph Smith</i> , sel. Joseph Fielding Smith [1976], 287-г үз
Хиламан 14:5–6, 20	Тэнгэр дэх тэмдгүүд болон гайхамшгуудын тухай бошиглол	Иоел 2:30–31; С ба Г 45:40
Хиламан 16:13–18	Тэмдгүүд, гайхамшгууд болон Христийн ирэлтийг үгүйсгэсэн нь	2 Петр 3:3–4; С ба Г 45:26

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэхүү хүснэгтийг бүгдийг нь эсвэл заримыг нь гэр бүлээрээ судал.

Хүмүүсийг хоёр дахь ирэлтэд

бэлтгэхэд нь туслах ямар мэдээллийг энэ хүснэгтээс хуваалцаж болохыг гэр бүлийн гишүүн бүрээс асуу.

“Маргааш Би бээр дэлхийд ирэх болно”

3 Нифай 1–7

- Самуелийн бошиглол биелэгдэхийг хүлээх зуур “хүмүүс ихэд уйтгарлан гуньж эхлэв” (3 Нифай 1:7). Тэдний уйтгарлан гуньж байсан шалтгаан нь юу вэ? (3 Нифай 1:5–9-г үз) Итгэлийнх нь улмаас

ирсэн сорилт бэрхшээлийг даван туулснаас гадна тэдгээр итгэгчид юу хийсэн бэ? (3 Нифай 1:8-г үз) Итгэл соригдох үед итгэлдээ үнэнч үлдэхийн тулд та юу хийж болох вэ?

36

- 3 Нифай 3:12–26-г унш. Эдгээр шүлгүүдэд Нифайчууд Гадиантоны дээрэмчдийн дайралтын эсрэг хэрхэн бэлтгэгдэж байгаа тухай гардаг. Тэрхүү аймшигт аюулын цаг үе дэх Нифайчуудын үйлдлээс та уруу таталт болон айдастай үед танд туслах юуг сурч болох вэ?
- Итгэлдээ үнэнч үлдсэнээр хүмүүсийн хүлээж авах ямар адислалууд байдаг вэ? (3 Нифай 10:18–19-г үз)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлээрээ 3 Нифай 5:13-г унш. Эдгээр шүлгүүд бошиглогч

Мормоны үгийг агуулсан гэдгийг тайлбарла. Тэгээд дараах асуултуудыг асуу:

- “Есүс Христийн шавь” болно гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Есүс Христийг дагах) Аврагчийг дагахын тулд гэр бүлээрээ болон хувиараа хийж болох ямар зүйлс байна вэ?

Ярилцлагын үеэр та “Come, Follow Me” (*Hymns*, no. 116), “More Holiness Give Me” (*Hymns*, no. 131), эсвэл “I’m Trying to Be like Jesus” (*Children’s Songbook*, 78–79) дууллуудыг дуулж болно.

“Мөн ирэх хэнийг боловч түүнийг Би хүлээн авах болно”

37

3 Нифай 8–11

Бошиглогч Самуел Аврагчийн цовдлолтын тэмдгүүдийн талаар бошиглодог. Түүний бошиглолуудыг Хиламан 14:20–27-гоос унш. Тэдгээр бошиглолуудын биелэлийг мэдэхийн тулд 3 Нифай 8–9-г унш.

- Сүйрлийн үеэр амьд үлдсэн тэдгээр хүмүүст Их Эзэн ямар урилга өгдөг вэ? (3 Нифай 9:13–14-г унш. 14-р шүлэг дээр гурван удаа давтагдсан *ирэх* гэдэг үгийг тэмдэглэж ав.) Та энэхүү урилгыг хүлээн авахын тулд юу хийж болох вэ?
- Олон хүн “нэг нэгээрээ” Аврагч дээр ирдэг (3 Нифай 11:15; 3 Нифай 17:25-г үз, энэ нь тэнд 2,500 хүн байсныг харуулдаг). Та Аврагчийн хайрын үлгэр жишээнээс юу сурч болох вэ?

- Есүс хүмүүсийн дунд “ямар ч сөргөлдөөнүүд” байх ёсгүй хэмээн заадаг (3 Нифай 11:22, 28). Яагаад сайн мэдээний сургаалын талаарх зөрчилдөөн нь аюултай байдаг вэ? (3 Нифай 11:29; С ба Г 10:62–63-г үз) Бид үнэн сургаалд хэрхэн нэгдэх вэ?

Гэр бүлийг ярилцлагын санаанууд

3 Нифай 11:1–17-г гэр бүлээрээ унш. Хэрэв тэд дахин амилсан Их Эзэн Нифайчуудын дунд ирэх үед байсан бол юу мэдрэх байсныг гэр бүлийн гишүүдээс асуу. Тэгээд “Easter Hosanna” (*Children’s Songbook*, 68–69) дуулыг дуулах эсвэл үгийг нь унш.

3 Нифай 12–15

3 Нифай 12–15 дахь Аврагчийн заасан зүйлсийг судлахдаа танд тохирсон чухал санагдаж буй тэдгээр сургаалуудыг ол.

Есүс Нифайчуудад “газар дэлхийн давс байх үүргийг би та нарт өгдөг” (3 Нифай 12:13) гэж хэлжээ. Энэ сургаалыг илүү сайн ойлгохын тулд дараах судруудыг унш.

Левит 2:13 С ба Г 101:39–40
Матай 5:13 С ба Г 103:9–10

- 3 Нифай 12:48-г унш. Төгс төгөлдөр болохын тулд яагаад бидэнд

Есүс Христийн Цагаатгал хэрэгтэй вэ? (2 Нифай 2:7–9; 3 Нифай 19:28–29; Моронай 10:32–33-г үз)

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлийн гишүүдэд нэг давстай, нэг давсгүй хоол өг. Тэд давс нь хоолны амтыг хэрхэн сайжруулдаг болохыг ойлгоно.

Харанхуй өрөөнд гар чийдэн асаах юм уу лаа асаа.

Дараа нь “газар дэлхийн давс байх” мөн “хүмүүсийн гэрэл байх” (3 Нифай 12:13–14) гэдэг нь юу гэсэн утгатайг ярилц.

**“Мөн эдүгээ болгоогтун, миний баясал
дүүрэн байна”**

3 Нифай 17–19

Та 3 Нифай 17–19-г судлахдаа Есүсийн хайрыг харуулж буй тэдгээр шүлгүүдийг ол. Та мэдэрсэн зүйлээ тэмдэглэлийн дэвтэртээ бичиж болно.

- Есүс яагаад “дахин хэсэгхэн зуур” хүмүүстэй хамт үлдсэн бэ? (3 Нифай 17:5–6-г үз) Энэ нь Түүний хайрыг хүмүүст хэрхэн харуулсан бэ? Та Есүс Христийн хайр болон танд хандуулах анхаарлыг хэрхэн мэдэрсэн бэ?
- Есүс Нифайчуудын дунд ариун ёслолыг танилцуулдаг. Та 3 Нифай 18:1–11-ээс ариун ёслолын талаар юу сурч байна вэ? Та ариун ёсло-

лоос долоо хоног бүр хүртэхийн тулд өөрийгөө хэрхэн бэлтгэх вэ?

- “Гэр бүлдээ Эцэгт хандан залбир” (3 Нифай 18:21) гэж Есүс заадаг. Гэр бүлийн залбирал гэр бүлд тань хэрхэн нөлөөлөх вэ? Гэр бүлүүд гэр бүлээрээ залбирах үүргээ хэрхэн илүү сайн биелүүлэх вэ?

Судрыг чанга уншихдаа та аяархан унших үедээ анзаараагүй сургаал болон үйл явдлуудыг илүү сайн ойлгоно. 3 Нифай 17-г чангаар унш. Унших зуураа Сүнсний нөлөөллийг сонсоорой. Танд илүү их сэтгэгдэл төрүүлсэн хэсгүүдийг тэмдэглэж авч болно.

Гэр бүлийн ярилцлагын санаанууд
Нифайчуудын дунд номлосон эхний хоёр өдрөө Аврагч хүүхдүүдэд үйлчилдэг. Гэр бүлээрээ 3 Нифай 17:11–24 мөн 3 Нифай 26:14–16-г унш. Тэгээд хүүхдүүдийг хайрлах Есүсийн хайрын талаар ярилц.

Ярилцлагын үеэр хамтдаа “Had I Been a Child” (*Children’s Songbook*, 80–81) эсвэл “When He Comes Again” (*Children’s Songbook*, 82–83) дуушуудыг дуулж болно.

“Тэгээд Би тэднийг цуглуулах болно”

3 Нифай 16; 20–21

3 Нифай 16, 3 Нифай 20, 3 Нифай 21 нь Есүс Христ амилуултынхаа дараа Нифайчуудтай хамт өнгөрөөсөн цаг хугацаандаа тэдэнд заасан зүйлсийг агуулдаг. Эдгээр бүлгүүдэд Их Эзэн сайн мэдээний Сэргээлт болон хожмын үе дэх Израилын угсааны цугларалтын талаар бошиглож заадаг.

- Яагаад Израил тараагдсан бэ? (3 Нифай 16:4-г үз) Израилын цугларалт гэж юу вэ? (3 Нифай 16:4, 12; 20:10–13-г үз)
- Израилын цугларалтанд Мормоны Номын гүйцэтгэх үүрэг юу вэ? (Жишээлбэл, 3 Нифай 16:4, 12 мөн 3 Нифай 20:10–13-г 1 Нифай 6:3–4, Мормоны Номын нүүр хуудастай харьцуулна уу) Сүмийн гишүүний хувьд Израилын

цугларалтанд таны гүйцэтгэх үүрэг юу вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Өрөөгөөр янз бүрийн зүйлсийг тараа. Тэдгээр зүйлсийг цуглуулахыг гэр бүлийн гишүүдээс хүс. Та цуглуулах гэдэг нь хамтад нь авчрах гэсэн үг гэдгийг тайлбарлаж болно.

Гэр бүлийн гишүүдийг тэдгээр зүйлсийг цуглуулсны дараа 3 Нифай 20:12–13-г унш. Тэнгэрлэг Эцэг дэлхий даяарх Өөрийн хүмүүсийг “тэднийг гэтэлгэсэн, Их Эзэн Бурханыхаа мэдлэгт” авчирснаар цуглуулах болно гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэгт Өөрийн хүмүүсээ цуглуулахад нь туслахын тулд бид хувиараа болон гэр бүлээрээ юу хийж болохыг ярилц.

40

“Тэрбээр тэдэнд бүх зүйлийг тайлбарласан болой”

3 Нифай 22–26

- Исаиагийн бошиглолоос эш татсаны дараа Есүс хүмүүст “тэдгээрийг хичээнгүйлэн судлахыг” (3 Nephi 23:1) зарлигладаг. Зүгээр л судруудыг уншихын оронд тэдгээрийг судална гэдэг нь юу гэсэн үг вэ?

- Мормон өөрийн бичиглэлдээ Есүсийн хүмүүст заасан зүйлүүдийн “багахан хэсгийг” (3 Нифай 26:8) багтаасан байдаг. Хэрхэн бид “агуу зүйлүүдийг” хүлээж авч болох вэ? (3 Нифай 26:9-г үз)

41

- 3 Нифай 26:19–21-г унш. Бид энэхүү жишээг гэрлэлт, гэр бүл, тойрог, гадастаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Есүс Нифайчуудын дунд байхдаа Елиагийн номлолын тухай Малахийн хэлсэн бошиглолоос хуваалцсан гэдгийг тайлбарла (3 Нифай 25:1–6). Энэхүү сургаал нь маш чухал бөгөөд Сүмийн бүх жишиг бүтээлд дурдагдсан байдаг.

Гэр бүлээрээ дараах судрын эшлэлүүдийг унш: Малахи 4:1–6; Лук

1:17; 3 Нифай 25:1–6; Сургаал ба Гэрээ 2:1–3; мөн Иосеф Смит—Түүх 1:37–39. Та гэр бүлийн гишүүдэд дараах судруудыг судар дээрээ тэмдэглэхийг зөвлөж болно.

Эдгээр судрууд нь гэр бүлийн түүхийн ажил болон ариун сүмийн ажилтай хэрхэн холбогдож байгааг тайлбарла. Ариун сүмийн ёслолуудад зориулж нас барсан өвөг дээдсийнхээ нэрийг олохын тулд хамтдаа ажиллах төлөвлөгөө гарга. Боломжинхоо хэрээр ариун сүмд хамтдаа үйлчлэх төлөвлөгөө гарга.

“Энэ бол Миний сайн мэдээ”

42

3 Нифай 27–30; 4 Нифай

- Есүсийн арванхоёр дагалдагч болох Нифайчууд Түүнээс Түүний Сүмийг хэрхэн нэрлэхийг асуудаг (3 Нифай 27:3-г үз). Тэрээр хариуд нь юу гэж хариулсан бэ? (3 Нифай 27:4–9-г үз) Их Эзэн Нифайчуудын дунд байсан Өөрийн Сүмийн адил сэргээгдсэн Сүмээ Өөрийнхөө нэрээр нэрлэхийг зарлигладаг (С ба Г 115:4). Сүмийг Есүс Христийн нэрээр нэрлэсэн гэдгийг санах нь бидэнд яагаад чухал байдаг вэ?
- 3 Нифай 27:13–21-г судлахдаа Есүс Христийн сайн мэдээний өөр өөр талыг эрж ол. Аврагч Түүний сайн мэдээний дагуу амьдардаг хүмүүст юуг амласан бэ? (3 Нифай 27:21–22-г үз)
- Өөрсдийнхөө хүсэлтийн дагуу гурван Нифай дагалдагч хувирч өөрчлөгддөг, өөрөөр хэлбэл “Бурханы зүйлийг болгоож болохын тулд” (3 Nephi 28:13–15) тэд маханбодын энэ биеэсээ үхэшгүй байдалд өөрчлөгддөг. Тийн тэд хувирч өөрчлөгддөг. 3 Нифай 28-р бүлэг

дэх түүх хувирсан биетийн тухай юу зааж байна вэ?

- Есүс Нифайчуудын дунд зочилсноос хойш олон жилийн турш “ямар ч -чууд” (4 Нифай 1:17) байсангүй. Энэ нь юу гэсэн үг вэ? (4 Нифай 1:2–3, 15–17-г үз) Хүмүүсийн дундах ялгаа, ялгаварлаас болж өнөөдрийн дэлхийд ямар асуудлууд үүсч байна вэ? Сайн мэдээ биднийг нэгдмэл байхад хэрхэн тусалж чадах вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

4 Нифай номыг хамтдаа унш. 4 Нифай 1:1–19-г уншихдаа амар амгалан, аз жаргал руу хөтөлдөг зан байдлыг жагсааж бич. 4 Нифай 1:20–46-г уншихдаа зөрчилдөөн, сүйрэл рүү хөтөлдөг зан байдал, үйлдлийг жагсааж бич.

Гаргасан жагсаалтуудаа хооронд нь харьцуул. 4 Нифай 1:1–19 дээр гарсан хүмүүс шиг болохын тулд гэр бүлээрээ юу хийж болох тухай ярилц.

“Та нар Их Эзэний замаас яахан салж чадаваа?”

43

Мормон 1–6; Моронай 9

- Мормон 15 настай байхдаа “Их Эзэнээр зочлогдон, мөн Есүсийн сайн сайхныг амталж мөн мэдэв” (Мормон 1:15). Бид хэрхэн Есүсийн сайн сайхныг мэдэх вэ?
- Мормоны цаг үед Нифайчуудын нийгэм ямархуу нөхцөл байдалтай байсан бэ? (Мормон 1:19; 2:8, 10, 18-г үз) Бид хэдийгээр ёс бус зүйлс газар авсан дэлхийд амьдарч байгаа ч гэсэн Мормоны адилаар итгэл, зөв шударга байдлаа хөгжүүлэхийн тулд юу хийж болох вэ?
- Мормоны хүмүүс Леменчүүдийг дайны талбарт ялах үед тэрээр “тэднийг хэлтрүүлсэн нь Их Эзэн байсныг тэд ухаарсангүй” (Мормон 3:3) хэмээн хэлдэг. Бидний хүлээж авдаг адислалууд Их Эзэнээс ирдэг гэдгийг ухаарах нь яагаад чухал вэ?

- Мормон 5:17–18-г унш. Аврагчийг дагадаггүй хүмүүс “далбаа эс бөгөөс зангуугүй хөлөг” лугаа адил байдаг шалтгаан нь юу вэ? Сайн мэдээ таны хувьд хэрхэн далбаа эсвээс зангуу байж болох вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Мормон 1:13–14 мөн Мормон 2:18-г гэр бүлээрээ унш. Тэгээд Мормон 1:15 мөн Мормон 2:19-г унш. Бид ёс бусаар хүрээлэгдсэн байсан ч гэсэн Их Эзэний сайн сайхныг мэдэж чадна гэдгийг онцол. Хэрэв бид Мормоны адилаар Их Эзэнийг дагахын тулд тэмцэж, сайн мэдээний тухай гэрчлэлдээ үнэнч байх юм бол “эцсийн өдөр өргөгдөх болно” (Мормон 2:19) гэсэн найдварыг олж чадна.

“Та нар өмнө минь буй мэтээр Би та нартай ярьж байна”

44

Мормон 7–9

Та Мормон 7–9-г судлахдаа эдгээр шүлгүүд дэх сургаалууд бүгд хожмын үед амьдарч байгаа хүмүүстэй холбоотой гэдгийг сана.

- Мормоны Номыг ил гарах үед дэлхийн нөхцөл байдал ямар байна гэж Мормон бошиггосон бэ? (Мормон 8:26–33-г үз) Мормон эцсийн өдрүүдийн талаар ийм тодорхой бошиглох болсон шалтгаан нь юу вэ? (Мормон 8:34–35-г үз)
- Эцсийн өдрүүд дэх бардамналын талаар Моронай юуг бошиггосон бэ? (Мормон 8:35–41-г үз)
- Эцсийн өдрүүд дэх зарим хүмүүс Бурхан бол “гайхамшгийн Бурхан биш” гэдэгт итгэнэ гэдгийг Моронай бошигложээ (Мормон 9:10). Хэрэв танд хэн нэгэн Их Эзэн гайхамшгийн Бурхан байгаагүй гэж хэлэх юм бол та юу гэж хариулах вэ? Их Эзэн бол гайхамшгийн Бурхан гэдгийг

гэрчлэхийн тулд ямар туршлагаас хуваалцах нь тохиромжтой вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Гэр бүлээрээ Мормон 8:34–35-г унш. Тэгээд хүн бүрээс ирээдүйн гэр бүлийн гишүүдээ зориулж захиа бичихийг хүс (хүүхэд, ач зээ нартаа гэх мэт). Бичихдээ тэдгээр ирээдүйн

гэр бүлийн гишүүд та нарын өмнө буй мэтээр бич. Захиандаа сорилт бэрхшээлийг үл харгалзан сайн мэдээний дагуу амьдрахад нь ирээдүйн гэр бүлийн гишүүдэд туслах зөвлөгөөг багтаа. Мөн захиануудаа найдвартай газар хадгалж ингэснээр тэдгээрийг ирээдүйн нэг өдөр тэд унших болно гэдгийг зөвлөж болно.

“Чиний нэгэн адилаар надад хүмүүн итгэж байсан нь үгүй”

45

Ифер 1–6

- Жаредын ах хөлгүүдийг хэрхэн гэрэлтүүлэх талаар Их Эзэнээс асуухад Тэрээр юу гэж хариулсан бэ? (Ифер 2:23–25-г үз) Их Эзэнээс тусламж хүсэхээс гадна өөрсдийн хийж чадах бүхнээ хийх нь яагаад чухал вэ?
- Өөрийгөө Жаредын ахад үзүүлэхээс өмнө Их Эзэн түүнээс юу гэж асуусан бэ? (Ифер 3:11-г үз) Жаредын ах итгэлийнхээ гүн гүнзгийг хэрхэн баталсан бэ? (Ифер 3:12-г үз) Түүний үлгэр жишээг дагахын тулд та юу хийж болох вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Ифер 6:1–12-г хамтдаа унш. Жаредын амлагдсан нутагт хүрэх аялал болон бидний амьдралын аяны хоорондох адил төстэй зүйлсийг олоход нь гэр бүлийн гишүүдэд туслахын тулд дараах асуултуудыг асуу:

- Их Эзэн “харанхуйд гэрэл өгөхийн” тулд чулуунуудыг хөлөгт тавьдаг (Ифер 6:3). Их Эзэн бидэнд ямар “гэрэл” өгдөг вэ?
- Жаредчууд аялалдаа зориулж хийж чадах бүх зүйлээ бэлтгэсний дараа юу хийдэг вэ? (Ифер 6:4-г үз) Та үүнтэй адил итгэлийг Их Эзэнд хэрхэн үзүүлж болох вэ?
- Салхи үлээж, тэднийг урагш туух үед Жаредчууд өдөр шөннийн турш юу хийж байсан бэ? (Ифер 6:8–9-г үз) Их Эзэнд магтаал өргөж болох ямар арга замууд байдаг вэ?
- Амлагдсан нутагт ирэх үедээ Жаредчууд юу хийсэн бэ? (Ифер 6:12-г үз) Бид Тэнгэр дэх Эцэгтээ эргэж очих үетэй энэ үйл явдал нь хэрхэн холбогдож байна вэ?

“Итгэлээр бүх зүйлс гүйцэлддэг”

Ифер 7–15

- Бурханд итгэдэг хүмүүсийг Ифер хэрхэн дүрсэлсэн бэ? (Ифер 12:4-г үз) Итгэл, найдвар хэрхэн бидэнд

зангуу болдог вэ? Итгэл Бурханыг алдаршуулах сайн үйлс рүү хадгалдаг, ямар жишээнүүд байдаг вэ?

46

- Моронай итгэлийг хэрхэн тодорхойлсон бэ? (Ифер 12:6-г үз)
“Итгэлийн тань сорилтын дарааг хүргэл та нар гэрчийг хүлээн авахгүй” гэдэг нь юу гэсэн үг вэ? Зовлон бэрхшээл, сорилт нь бидний итгэлийг хэрхэн хүчирхэгжүүлж мөн харуулдаг вэ?
- Хэрэв бид Түүний өмнө өөрийгөө даруусгаж, Түүнд итгэлтэй байх юм бол Их Эзэн “сул дорой зүйлүүдийг [маань] хүчирхэг болгож өгнө” (Ифер 12:27). Энэхүү амлалт хэрхэн судруудад, таны амьдралд болон бусдын амьдралд гүйцэлдэж байна вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Хайрум Смит Картейж шорон руу явахаар бэлэн болсныхоо дараа Ифер 12:36–38-р шүлгийг уншиж мөн дараах хуудсыг эргүүлжээ (С ба Г 135:4–5). Картейж шоронд Хайрум Смит болон Иосеф Смит хоёр алагджээ. Гэр бүлийн гишүүдээс тэдгээр шүлгүүдийг уншихыг хүс.

- Эдгээр шүлгүүд нь хэрхэн тайтгарлыг өгсөн бэ? Судрын ямар эшлэл танд хүчийг өгч, таныг тайтгаруулсан бэ?

“Тэднийг зөв замд байлгахын тулд”

47

Моронай 1–6

- Моронай 2–5-р бүлэг яагаад бидний өдрүүдэд чухал вэ? Энэ нь өөр эрин үе дэх Их Эзэний Сүмийн ёслолуудыг мэдэхэд танд хэрхэн тусалж байна вэ?
- Бид ариун ёслолоор дамжуулж ямар гэрээ хийдэг вэ? (Моронай 4:3; 5:2-г үз) Бид хариуд нь юуг хүлээж авна гэсэн амлалт өгөгдсөн бэ? Танд ариун ёслолоос хүндэтгэл бишрэлтэй, зохистойгоор хүртэх үед ямар мэдрэмж төрдөг вэ?
- Хүмүүс баптисм хүргэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсныхаа дараа “Христийн сүмийн хүмүүсийн дунд тоологддог байв; тэдний нэрс тэмдэглэгддэг байв” (Моронай 6:4). Яагаад тэдний нэрс тэмдэглэгддэг байсан бэ? (Моронай 6:4-г үз) Та сүмийн гишүүн болоод удаж байгаа болон дөнгөж гишүүн болсон хүмүүс

“Бурханы сайн үгээр дурсагдан мөн гэжээгдэхийг” харах Сүмийн зорилгод хэрхэн тусалж чадах вэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Хэрэв танай гэр бүлийн гишүүд шинэ хөрвөгчид бол Сүмд элсэхэд ямар байсан тухай тэдэнтэй ярилц. Сүмд нэгдсэнээр ирсэн баяр баясгалан болон сорилт бэрхшээлийн талаар ярих боломжийг гэр бүлийн гишүүдэд олго. Хэрэв танай гэр бүлийн гишүүд Сүмийн гишүүн болоод удаж байгаа бол дараах асуултыг асуу. Хэрэв сүмд анх удаа ирж байгаа бол та нарт ямар санагдах вэ?

Гэр бүлийн нэг гишүүнээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн өгсөн дараах зөвлөгөөг уншуул.

“Сүмд хөрвөгчдийн тоо эрчимтэй өсөн нэмэгдэж байгаа энэ цаг үед тэднийг замаа олоход нь туслахын тулд бид илүү шаргуу хөдөлмөрлөх

хэрэгтэй байна. Тэдний хүн нэг бүрт гурван зүйл хэрэгтэй байдаг: найз, үүрэг даалгавар, 'Бурханы сайн үгээр' тэжээгдэх (Моронай 6:4)" (in Conference Report, 1997 оны 4-р

сар, 66; эсвэл *Ensign*, 1997 оны 5-р сар, 47).

- Уг зөвлөгөөг дагахын тулд бид юу хийж болох вэ?

“Христэд ир”

Моронай 7–8; 10

Моронай 7–8 –р бүлэг нь Моронайн Эцэг Мормоны заасан зүйлсийг агуулдаг. Моронай 10-р бүлэг нь Моронайн хамгийн сүүлчийн гэрчлэлийг агуулдаг.

- Мормон Сүмийн гишүүдийг “Христийн амгалан дөлгөөн дагалдагчид” хэмээн хэлдэг (Моронай 7:3). Ямар үндэслэлээр Мормон ийм дүгнэлтэнд хүрсэн бэ? (Моронай 7:4–5-г үз) Бид хэрхэн “Христийн амгалан дөлгөөн дагалдагчид” болох вэ?

Моронай “ухуулах замаар хэдэн үг хэлснийхээ дараа” (Моронай 10:2) өөрийнхөө бичиглэсэн цэдгийг төгсгөдөг. *Ухуулах* гэдэг үг нь зөвлөх эсвэл шаардах гэсэн утгатай. Та Моронай 10-г судлахдаа *ухуулах* гэдэг үгийг тэмдэглэж болно. Уг бүлэг дэх Моронайн хэлсэн ухуулах үгсийн ач холбогдлыг болон утгыг нь тунгаан бод.

- Моронай сүнслэг бэлгүүдийн талаар юу заасан бэ? (Моронай 10:8–19-г үз)
- Моронайн “Христэд ир” хэмээх ухуулга Мормоны Номын ерөнхий

захиасыг хэрхэн тусгаж байна вэ? (Моронай 10:30, 32). Энэ жил Мормоны Номоос судалсан тань танд Христэд ирэхэд хэрхэн тусалсан бэ?

Гэр бүлийн ярилцлагын санаанууд

Мормоны Номын талаарх гэрчлэлээ хуваалцаж, гэр бүлийн гишүүдийг ч мөн адил гэрчлэлээ хуваалцахыг урь. Тэгээд Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны хэлсэн дараах үгсийг унш.

“Мормоны Номыг дөрөв дэх жил бүр Ням гарагийн анги болон семинарт үздэг. Энэхүү дөрвөн жилийн загварыг гэр бүлийн гишүүд хувиараа болон гэр бүлээрээ судраас судлахдаа ашиглах шаардлагагүй. Түүнчлэн бусад ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг нь мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртдог” (*History of the Church*, 4:461). Энэхүү номыг бид өдөр бүр унших хэрэгтэй” (in Conference Report, 1988 оны 10-р сар, 3; эсвэл *Ensign*, 1988 оны 11-р сар, 4).

Гэр бүлийн гишүүдийг Мормоны Номыг үргэлжлүүлэн судалж, үүнийг бусадтай хуваалцахыг урь.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



35684 363